



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5-30
<hr/>	
<i>1 Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	5-8
<i>2. Гурилын үнийн өсөлтийн талаарх Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын мэдээлэл сонсох</i>	8-30

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
12 дугаар сарын 05-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 56 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Саранчимэг, Г.Дамдинням, Н.Наранбаатар, Д.Өнөрболор;
Чөлөөтэй: Ц.Анандбазар, Х.Болорчулуун, Н.Ганибал, Г.Тэмүүлэн.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Ц.Цэрэнпунцаг нар үг хэлэв.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Жууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Батжаргал тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен үг хэлэв.

Ж.Батжаргал: Байнгын хорооны гишүүдийн гаргасан саналаар 12 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглаварт “Мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, авч хэрэгжүүлэх арга хэмжээ” гэсэн асуудлыг нэмж оруулья гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Ж.Батжаргал: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Гурилын үнийн өсөлтийн талаарх Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Довчинсүрэн, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын орон тооны гишүүн О.Батмөнх, мөн газрын Өрсөлдөөний зохицуулалт, зах зээлийн судалгааны газрын дарга Ч.Однасан, Хууль, эрх зүй, дотоод хяналтын газрын дарга У.Халиунаа, мөн газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зар сурталчилгааны газрын дарга Ц.Тэрбиш, мөн газрын ахлах мэргэжилтэн Х.Орхон, Өрсөлдөөний зохицуулалт, зах зээл судалгааны газрын ахлах мэргэжилтэн М.Даваажаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал байлцав.

Гурилын үнийн өсөлтийн талаарх мэдээллийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Өрсөлдөөний зохицуулалт, зах зээлийн газрын Зах зээл судалгааны газрын дарга Ч.Однасан танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Т.Энхтүвшин, Г.Мөнхцэцэг, Б.Бейсен, Ц.Идэрбат, Т.Аубакир, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Довчинсүрэн, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Өрсөлдөөний зохицуулалт, зах зээлийн судалгааны газрын дарга Ч.Однасан, Хууль, эрх зүй дотоод хяналтын газрын дарга У.Халиунаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Гурилын үнийн өсөлтийн талаарх Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын мэдээллийг сонсов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 30 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 13 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их засаг”
танхим 11 цаг 56 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Батжаргал: Байнгын хорооныхоо эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Байнгын хорооны гишүүн Аубакир, Жадамбын Бат-Эрдэнэ, Буланы Бейсен, Хаянгаагийн Болорчулуун, Гочоогийн Ганболд, Цагаанхүүгийн Идэрбат, Мөнхцэцэг ирцэд орчихсон юм уу? Ганзоригийн Тэмүүлэн, Цэвэгдоржийн Туваан, Одонгийн Цогтгэрэл, Цэдэндамбын Цэрэнпунцаг, Төмөртоогоогийн Энхтүвшин, Жигжидийн Батжаргал нарын гишүүд хүрэлцэн ирж Байнгын хорооны хуралдааны ирц 52.6 хувьтай байх тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг танилцуулъя.

Байнгын хорооны тогтоолын төсөл. Байнгын хорооны 12 дугаар сарын хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай тогтоолын төсөл байгаа юм.

2. Гурилын үнийн өсөлтөд хяналт шалгалт хийсэн талаарх Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын

мэдээлэл сонсох гэсэн ийм 2 асуудал байна.

Өнөөдрийн хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөтэй холбогдуулж саналтай гишүүн байна уу? Нэрсээ өгөөрэй. Цэрэнпунцаг гишүүнээр тасаллаа. Аубакир гишүүн.

Т.Аубакир: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Хэлэлцэх асуудал дээр санал байна. Энэ өвөлжилт мэдэгдэхүйц хүндрээд ирсэн энэ үед гурил тэжээлийн хангалтын асуудлыг, тэжээлийн нөөцийг холбогдох байгууллагуудаас мэдээг нь аваад үүнтэй уялдуулаад ирэх хавар хүртэл 3, 4 сар хүртэл энэ зуд зурхан үргэлжлэх учраас нөөцийг нь яг холбогдох байгууллагуудаас сонсоод түүнтэй холбоотой шаардлагатай бол алслагдсан аймгуудын тэжээлийн хангамж нэгдүгээрт,

Хоёрдугаарт гурилын хүнсний хангамжтай холбоотой мэдээллүүдийг сонсоод үүнтэй холбоотой гааль, НӨАТ-аас чөлөөлөх боломжийг судлаад Засгийн газар чиглэл өгсөн ийм тогтоол гаргавал Байнгын хороогоороо хэлэлцээд тогтоол гаргавал яасан юм бэ гэсэн ийм саналтай байна. Яагаад гэвэл одоо улсын хэмжээнд цасан бүрхүүл бүх нутгийг хамарсан хангайн нутаг, говийн нутаг, Алтайн нутгуудаар асар хүндрэхээр төлөвтэй болчихлоо.

Бид нар 71 сая гаруй мал өвөлжинө гэж байгаа. Эдгээрийнхээ тэртээ тэргүй бэлчихгүй бэлчээрээсээ тэжээл байхгүй учраас гар дээрээс тэжээх нөхцөлийг нь бүрдүүлээд энэ импортын гурил тэжээлийн гаалийг НӨАТ-тай нь чөлөөлөх бололцоог

холбогдох байгууллагад нь чиглэл өгөөд судлуулаад үүнтэй холбоотой Засгийн газар руу чиглэл өгсөн тогтоол гаргая гэсэн ийм саналтай байна.

Ж.Батжаргал: Энэ асуудлаар Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр мэдээлэл хийгдэж манай Улсын Их Хурлын гишүүд асууж тодруулж санал бодлоо илэрхийлж Улсын Их Хурлын даргаас энэ МАА-н өвөлжилтийн байдалтай холбогдуулж ойрын хугацаанд авч хэрэгжүүлэх ажлын чиглэл өгөгдсөн. Тэр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэлийг манай байнгын хороо татаж авч ойрын хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж яг тэр дагуу судалгаа тооцооллыг нь холбогдох байгууллагуудаар хийж ойрын хугацаанд Байнгын хороо руу асуудлаа оруулж ирэхээр ингэж төлөвлөж ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Өнөөдрийн хуралдаанаар бэлтгэл хангагдаагүй тул орж ирэх боломжгүй байна.

Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Ер нь Аубакир гишүүний асуулт санал давхацчихлаа. Өнөөдрийн энэ хуралдаанаар бид нар бас нэг ийм Байнгын хорооны тогтоолын төсөл санаачлаад эндээ оруулаад хэлэлцвэл яасан юм. Нөгөө санаачилга гаргая гэсэн. Тэгэхээр зэрэг сая дөнгөж түрүүчийн чуулганаар сонссон учраас жоохон хугацаа давчуу байгаа юм байна гэж ойлголоо.

Батжаргал дарга аа тэгэхээр зэрэг ерөнхийдөө бас жоохон шахаж байгаад бид нар энэ цас зуд чинь бид нарыг хүлээхгүй эртхэн шиг тийм арга хэмжээ авах ёстой. Ялангуяа баруун аймагт тэр хил гаалийнх нь татварыг баруун 5 аймагт орж ирж байгаа

гаалиар, хил боомт дээр нь хөнгөлөх асуудлыг шуурхай шийдчихвэл ядахад малчид маань нэг хямдхан гурилтай, мал нь нэг гаднаас ойрхон тэжээл оруулаад ирвэл хямдхан тэжээлтэй байх. Ийм бололцоог нь хангах ёстой.

Хоёрдугаарт Онцын онцгой комиссоос бид нар яг энэ мэдээлэл сонсохдоо байна шүү дээ Батжаргал дарга аа нэг тодорхой ямар нөөцтэй байгаа юм, ямар тэжээл, өвс тэжээл нь яг ямархуу хэмжээтэй байгаа юм. Ер нь ноднин нэг арга хэмжээ авсан та мэдэж байгаа. Цас зудтай байгаа газруудаа 50 хувь тэжээлээ хямдруулсан.

Тийм ээ энэ жил энэ арга хэмжээгээ авч хийх юм уу үгүй юу. Олон аймаг хамарчихсан хүндрэл ямар байгаа юм. Энийгээ эртхэн нэг тодорхой бодлогоо гаргачихвал аймгууд өөрсдөө бас нэг сая орон нутгийнхаа төсвийг баталлаа. Энэ дээрээ бас малчдадаа тусална гээд малчдынхаа бас энэ тэжээл малын тэжээлийг нь бэлдэх тал дээр бас нэг жоохон мөнгө тавьчихсан. Энийгээ яаж зарцуулах вэ гээд шийдвэр гаргах гээд хүлээгээд байгаа. Эртхэн одоо энэ гадна талаасаа авчиръя гэж байгаа.

Ялангуяа манай Завханы хувьд араасаа Тува талаасаа Оросоос авч ирье гэж байгаа тэжээл эд нартайгаа үнийг нь харьцуулж үзээд цаашидаа энэ онцгой комиссын нөөцөд байгаа энэ өвс тэжээлийнхээ бодлогыг тодорхой болгох юм бас нэг харьцуулж үзэж байгаад хямдхан сонголтоо хүртээмж ахиухан болгохын тулд чанар үнийг нь харж байгаад ингээд сонголтууд хийж бас бодлого гаргая гээд шахаад байгаа учраас энэ талаараа ойрын үед цөмөөр ч гэсэн Байнгын хороон дээр энэ саяын чиглэл өгсний дагуу энэ чиглэлийнх нь дагуу ажилласан Засгийн газрын бас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг нь авч сонсоод тэгээд 1 Байнгын хороон

дээр бүүр нэг их урт сунжирсан биш ерөнхий биш тодорхой 2 гуравхан юм заасан.

Гурил тэжээл дээр яг арга хэмжээ авах улсын нөөцөд байж байгаа гурил өвс тэжээлийнхээ яаж тарааж хүртээмж ямар байх талаар бодлогыг нь тодорхой сонсмоор байна аа.

Тэгвэл дараагийн Байнгын хороон дээр энэ асуудлыг хэлэлцэх юм байна гэж ойлголоо.

Ж.Батжаргал: Баярлалаа. 2 гишүүний асуултад ерөнхийдөө бэлтгэлийг нь хангаж дараагийн хуралдаанаар хэлэлцье гэсэн санал дээр бүгд тогтлоо гэж ингэж ойлгож байна. Тийм учраас Байнгын хорооны өнөөдрийн хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөө батлагдлаа.

Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу *Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.*

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын дарга 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 199 дүгээр захирамжийг баталсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд энэ дарааллыг үндэслэн хэлэлцэх асуудлын цаглаварыг Байнгын хороо баталж мөрдүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн

байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай тогтоолын төслийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Тогтоолын төсөл цаглавартай холбогдуулж асуулттай гишүүд байна уу? Үгүй яг цаглавар дээрээ л ярья. Асуулт байна уу? Асуулт байхгүй байна.

Тогтоолын төсөл цаглавар дээр саналтай гишүүн байна уу? Тэгвэл тасаллаа. Та дараад ор л доо. Тэгвэл Бейсен гишүүнээр тасаллаа. Бейсен гишүүн саналаа хэлье.

Б.Бейсен: Энэ цаглавар дээр энэ зудын байдалтай бас юм оруулах шаардлагатай байна. Энд орон нутагт биш, баруун аймагт Баян-Өлгийд 9 сарын сүүл, 10 сарын эхээр нойтон цаас 50 см орсон. Тэгээд доод талаараа мөстөж хөлдсөн. 10 сард өвөлжөөнд орчихсон. Одоо энэ өвс бараг дуусаж байгаа юм байна. Нөгөө талаараа ан амьтан бас айлуудын малчдын бэлчээр хот руу орж ирж байгаа. Тэгээд энэнтэй холбоотой энэ өвс тэжээл татах асуудал зудын байдлыг бас тухайн үед нь хэлэлцэж байгаагаар тогтоохгүй бол манай баруун аймгийн хувьд бас онцлогтой. Зуншлага муу болсон. Нөгөө талаар ноднин та бүгд мэдэж байгаа хивэг бол 80 мянга хүрсэн. Пресс өвс 45 хүрсэн. Одоогийн байдлаар 16-аас 25 мянга хүрчихсэн байна.

Тийм учраас энийг яахгүй бол манай аймагт бараг 6 сар хүртэл ногоо гардаггүй шүү дээ. Ерөөсөө энэ талын асуудал Байнгын хорооны дарга тусгаад яахгүй бол цаг үеийн байдалтай холбоотой хүндэрлээ. Нөгөө талаар энэ гурилын асуудал байгаа. Хилийн цаана 45-аас 52 мянган төгрөгийн хооронд ингээд гурил тийм байгаа гэтэл 120 мянгаар авч байгаа. Энийг гаалийнхнаас хөнгөлөх асуудал дээр бас тухайн энэ цагийн байдалтай холбоотой малын хивэг тэжээлийг хөнгөлөх, гаалийн

татвараас чөлөөлөх юм уу хөнгөлөх асуудал дээр тухайн энэ байдалтай холбоотой энэ цаглаварт аа туссан нь зөв байх гэсэн санал хэлж байна аа.

Ж.Батжаргал: Байнгын хорооны гишүүдээс гарч байгаа саналыг үндэслээд байнгын хорооны 12 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглаварт МАА-н өвөлжилтийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, авч хэрэгжүүлэх арга хэмжээ гэсэн нэртэй хэлэлцэх асуудлыг нэмж оруулъя гэдэг саналыг нийтээрээ нэг гаргаж байна.

Тийм учраас энэ асуудлаа дэмжье гэсэн саналын томъёоллоор хурааж байна. Хэлэлцэх асуудалдаа нэмж оруулъя.

Санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж цаглаварт нэмж тусгагдлаа.

Ингээд байнгын хорооны 12 сард хэлэлцэх цаглавар батлах тухай тогтоолын төслийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Дэмжиж байгаа гишүүд саналаа өгөөрэй.

Хөөе саналаа өгөөрэй санал хураалтад оролцсон гишүүдийн 63.6 хувийн саналаар дэмжигдэж, Байнгын хорооны тогтоол батлагдлаа. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

12.08 цагт

Дараагийн асуудлыг хэлэлцье. Гурилын үнийн өсөлтөд хяналт шалгалт хийсэн талаарх Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын мэдээлэл сонсох.

Ажлын хэсгийг оруулъя. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Д.Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга байна уу? Оруулаарай. Довчинсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын дарга байна уу? Довчинсүрэн оруулъя. О.Батмөнх Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын орон тооны гишүүн, Ч.Однасан мөн Газрын өрсөлдөөний зохицуулалт зах зээлийн судалгааны газрын дарга, У.Халиунаа. Мөн Газрын хууль, эрх зүй дотоод хяналтын газрын дарга, Ц.Тэрбиш мөн газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зар сурталчилгааны газрын дарга, Х.Орхон мөн газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зар сурталчилгааны газрын ахлах мэргэжилтэн, М.Даваажаргал мөн газрын Өрсөлдөөний зохицуулалт зах зээл судалгааны газрын ахлах мэргэжилтэн, А.Есөн-Эрдэнэ дарга Довчинсүрэн дарга нар суугаарай. Ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүн байна.

Гурилын үнийн өсөлтийн талаарх Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын мэдээллийг Өрсөлдөөний зохицуулалт зах зээлийн газрын Зах зээл судалгааны газрын дарга Ч.Однасан танилцуулна.

Однасан дарга мэдээллээ хийе. Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгье.

Ч.Однасан: Та бүхний энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас 2022, 2023 онуудад гурилын зах зээлд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байгаа. Энд бол нэгдүгээрт нь улаан буудайн гурилын зах

зээлд давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох судалгаа 2022 онд хийсэн, улаан буудайн гурилын үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд 2022 онд 11 сард шалгалт хийгээд гурилын үйлдвэрлэл эрхлэгч аж ахуй эрхлэгчид холбогдуулан зөрчлийн хэрэг нээж шалгасан. 2022, 2023 онд. Мөн хамгийн сүүлд улаан буудайн гурилын үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтыг хийсэн. Энийг бол бид нар 2023 оны 7 сарын 1-ний өдрийн байдлаар судалгааг хийсэн байгаа. Энэ судалгааг бол гишүүд та бүхэнд тусгайлан хүргүүлсэн. Улаан буудайн гурилын зах зээлд давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох судалгааны хүрээнд давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийн судалгааг хийгээд, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын хуралдаанаар оруулж хэлэлцүүлсэн.

Энэ дээр бол давамгай байдалтай аж ахуй эрхлэгч бол тогтоогдоогүй. Улаанбаатар гурил бол хамгийн их буюу зах зээлд 32.88 хувийг, Алтан тариа бол 19.89 хувийг эзэлж байгаа. Энэ дээр бид бол харилцаа хамаарлаар нь мөн Өрсөлдөөний тухай хуулийн 5 дугаар зүйлээ үндэслээд харилцаа хамаарлаар нь тогтоох талаар бас судалгаа хийж үзсэн. Энэ бид нарын судалгаа хийгээд Улаанбаатар гурил, Од, групп 2-ыг харилцаа хамаарлаар давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээр тогтоох 39.8 хувийг эзэлж байсан учраас тогтооё гэсэн энэ асуудлыг боловсруулаад хуралдаанаар хэлэлцүүлэх явцад од групп бол өмчлөгчөө сольсон учраас харилцаа хамаарлаар тогтоогдоогүй байгаа юм аа.

Дараагийн улаан буудайн гурилын үйлдвэрлэл 2022 онд хийсэн хяналт шалгалтаар бол гурил үйлдвэрлэгч аж ахуй эрхлэгчид үнээ нэмсэн учраас энд мөн картеллийн шинж чанартай үйлдэл

байна гэж үзсэн учраас бид нар зөрчлийн хэрэг нээж шалгасан. Энэ зөрчлийн хэргийг нээж шалгахад бол Монголын гурил үйлдвэрлэгчдийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн холбоо бол мэдэгдэл хийсэн. Энэ мэдэгдлийн дагуу бол Улаанбаатар гурил, Од групп, Алтан тариа гээд компаниуд үнээ нэмсэн. Энэ холбооны гишүүн нь Улаанбаатар гурил, Од групп 2 байсан. Алтан тариа гишүүн биш байсан учраас Улаанбаатар, Од групп дээр картеллаар зөрчлийн хэрэг нээж шалгаж шүүхийн шатанд асуудал хэлэлцэгдээд явж байна аа.

Хамгийн сүүлд хийсэн хяналт шалгалтын хүрээнд бид бол Монгол Улсын Засгийн газраас гурил үйлдвэрлэгч аж ахуй эрхлэгчдийн талаар болон улаан буудайн тариалалтын талаар нэлээдгүй ажил хийж гүйцэтгэсэн. Энд бас тодорхой тооны аж ахуй эрхлэгчид бол бас хөнгөлөлттэй зээлийг олгож ирсэн байгаа. Энэ хөнгөлөлттэй зээлийг бол олгосныхоо дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бол гэрээ байгуулж ажилласан. Энэ хяналт шалгалтын гол дүгнэлт гэрээний үүргийн биелэлт бол бид нар хангалтгүй байна гэж ингэж дүгнэсэн.

Яагаад гэхээр гэрээгээр бол үнийг тогтвортой байлгах ийм үүрэг хүлээсэн боловч аж ахуйн нэгжүүд бол үнээ нэмсэн ийм асуудлууд бол шалгалтаар бол тогтоогдсон. Ер нь бол бид яагаад одоо энэ гурилын үнийг бас өссөн нөхцөл шалтгаан нь үндэслэлгүй байна вэ гэж үзсэн бэ гэхээр гурил үйлдвэрлэгчид маань бол 2021 онд улаан буудайг нэг тонн тутамд нь дунджаар 698.8 мянган төгрөгөөр худалдан авч байсан бол 2022 онд нэг тонн тутамд дунджаар 883.6 мянган төгрөгөөр худалдан авсан. Эндээс бол улаан буудайн үнийн өсөлт бол 26.4 хувь байна гэж ингэж тооцоолж гаргасан.

Гэтэл гурил үйлдвэрлэгчдийн одоо судалгаан дээр үндэслээд гурил үйлдвэрлэгч маань үнийн өсөлт нь дунджаар 52.3 хувиар өссөн байна. Энэ гурил үйлдвэрлэгчдийн гол түүхий эд болох улаан буудайн үнэ 26.4 хувиар өсөөд байхад 1 кг тутам дахь гурилын үнэ 52.3 хувиар өссөн байна гэдэг нь бол үйлдвэрлэгчид үнээ үндэслэлгүй нэмсэн гэж ийм дүгнэсэн байгаа юм аа. Энэ шалгалтынхаа дүнг бид 7 сард Шадар сайдад танилцуулсан. Шадар сайдаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд бол чиглэл хүргүүлэх тухай 2023 оны 7 сарын 26-ны өдрийн 2/478 тоотойр ийм албан бичгүүд хүргүүлж ийм тодорхой арга хэмжээнүүдийг бид нар авч ажилласан.

Баярлалаа.

Ж.Батжаргал: Мэдээлэл болсон уу? Асуултад хариулъя аа. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын мэдээлэлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Идэрбат гишүүнээр тасаллаа.

Туваан гишүүн.

Ц.Туваан: Монголчуудын хүнсний хэрэглээний хүнсний гол 2, 3 нэр төрлийн бүтээгдэхүүний нэг бол гурил. Ер нь Монголчууд хүнсэндээ гурилыг мах, гурил 2-ыг маш түгээмэл хэрэглэдэг. Тэгэхээр энэ гурилын үнийн асуудал бол өөрөө маш чухлаар яригддаг, хурцаар яригддаг ийм асуудал байгаа. Тэгээд энэ асуудал өнөөдөр Байнгын хорооны хуралдаанд орж ирж байна. Хөдөө орон нутагт иргэдтэй уулзаад явахаар ерөөсөө манайхан чинь гол хэрэглээ бол 1 дүгээр гурил гэж ярьдаг. Энэ гурилынхаа 25 кг, 50 кг-ийн гурилаар хөдөө орон нутагт хэмждэг. Улаанбаатар хотод бол 1, 2 кг-аар савласан гурилууд.

Гурилын борлуулалтаар үнээ ингээд хэмждэг. Тэгэхээр хүмүүсийн ярьж байгаа зүйл гурилын үнэ өссөн. Одоо 25 кг-ын гурил бол 55 мянгаас дээш гараад явчихсан зарим сумдуудад 60 мянга хүрчихсэн. 50 кг-ын гурилын үнэ ингээд 110 мянгаас дээш ингээд гараад явчихлаа гээд байгаа юм. Тэгэхээр энэ эргээд иргэдийн нөгөө орлого багатай байгаа энэ үед бол амьдралд нь хүндээр тусаад байгаа учраас энэ асуудал сөхөгдөж байгаа.

Тэгэхээр энэ яагаад энэ гурилын үнэ өсөөд байгаа асуудлыг сая энэ Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас ярьж байна л даа. Энэ бол үндэслэлгүй нэмэгдэж байна гээд. Тэгэхээр энэ дээр бол та бүхэн бас юу гэдэг юм арга хэмжээ авах юм уу, эс үгүй бол ямар хуулийн зохицуулалт байдаг юм бэ? зүгээр ингээд нэг дүгнэлт гаргаад ингээд орхичих юм уу гэдэг нэг асуудал байгаа юм.

Хоёрдугаарт энэ ажлын хэсэгт яамныхан оролцсон. Энэ жилийн ургацын эцсийн баланс гарсан уу ер нь юу болов оо? Нэг урьдчилсан баланс яамныхан хүргүүлсэн байна лээ, танилцсан. Тэрэн дээр минийхээр энэ борлогдоогүй улаан буудайн үлдэгдэл чинь их байгаа. Хөдөө орон нутгийн ялангуяа энэ газар тариалангийн гол бүс нутаг болсон Төв аймаг, Сэлэнгийн тариаланчдаас маш их ярьж байгаа юм. Бид нарын будаа хэвээрээ байгаа. Тэгээд та хэдийн гаргаж өгсөн баланс дээр байгаа тоо чинь бараг ерэн хэдэн мянга гэсэн үү тийм тоо руу орчихсон байгаа юм.

Тэгэхээр энэ зөрөө хаана гараад байна аа? Энэ гурилууд, улаан буудай яагаад борлогдохгүй байгаа юм? Бид хэд бол? Тэрэн дээр угаасаа ер нь бол энэ байгаль, цаг уурын нөхцөл, дээрээс нь улаан буудай энэ намрын ургац

хураалтын үе дээр бас нэлээн ангилан хийсэн газрууд бол нэлээн харласан.

Дээрээс нь түрүүн дээрээс соёолсон асуудлууд байгаа. Тэгэхээр энэ үлдэгдэл улаан буудайг одоо яах юм бэ гэдэг асуудал дээр нэг тэртээ тэргүй гурилын асуудал ярьж байгаа үе дээр нэг тайлбар хэлээдхээч яг энэ салбарын яам дээр.

Гурав дугаар асуудал нь энэ гурил үйлдвэрлэлийн юун дээр чинь завсарт нь хивэг гэж нэг монголчуудын ганцхан хэрэглэж сурсан түгээмэл хэрэглэдэг малын тэжээл байгаа юм. Бусдыг нь манайхан төдийлөн хэрэглэдэггүй болон хэрэглэж сураагүй. Тэгэхээр одоо хөдөө орон нутаг дээр энэ зуд турхан ер нь болох нь тодорхой болчихлоо. Маш олон газар хүндэрчихлээ. Цаг агаар ойр ойрхон муудаж байна. Тэгэхээр энэ үе дээр нэг асуудал үүсдэг нь энэ хивгийн үнийн асуудал.

Тэгэхээр энэ Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрынхан маань энэ дан ганц гурилын үнэтэй холбоотой асуудал ярив уу, судлав уу? Эс үгүй бол энэ хивгэн дээр та хэд дээр мэдээлэл байна уу? Одоо манайхан чинь 25 кг-аар савласан хивгийг ярьдаг. Зарим нь иргэд кг-даа хүрэхгүй байна гэдэг асуудал.

Хоёрдугаарх нь маш өндөр үнэтэй байна гэдэг асуудал. Одоо тэгээд л бараг эрчимжсэн аж ахуй эрхлэгчид болон малчид ер нь их өндөр үнэтэй байна. 25 мянгаас дээш гараад явчихлаа гээд байгаа юм. Энэ дээр та хэд судалгаа байна уу?

Ж.Батжаргал: Туваан гишүүний асуултад хариулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Есөн-Эрдэнэ дарга, ажлын хэсгийн 1 дүгээр микрофон дээр

очъё. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофоныг өгье.

Д.Есөн-Эрдэнэ: Сайн байцаана уу? Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Есөн-Эрдэнэ. Туваан гишүүний асуултад хариулъя.

Энэ жил ургац хураалтын дүн гарсан. Нийтдээ 456 мянган тонн үр тариа хурааж авсан. Үүнээс нь 434 мянган тонн улаан буудай хурааж авсан байгаа. Улаан буудайн энэ жилийн хувьд бол бас 4, 5 дугаар саруудад хүйтэн сэрүүн, хур тунадас ихтэй байсантай холбоотойгоор хаврын тариалалтын ажил бас тодорхой хэмжээнд 5-7 хоноогоор хожуу эхэлсэн.

Харин ургалтын хугацаанд бол бас хур тунадас ахиу байсан нь бол цаг агаарын тааламжтай хур тунадас ингээд ахиу орсноор таримлын өсөлт, хөгжилтөд бас эергээр нөлөөлсөн хэдий ч бас 9 дүгээр сарын 2, 3 дугаар 10 хоногт үргэлжлэн орсон их хэмжээний борооны улмаас бол бас буудайн чанарт их өөрчлөлтүүд гарсан.

Тэгэхээр одоо бол бас гурилын үйлдвэрүүд улаан буудай худалдаж авч байна. Нийтдээ нэг гурил үйлдвэрлэлд 175 мянган тонн дан гурилын үйлдвэрүүд авсан байгаа. Мөн Хөдөө аж ахуйг дэмжих сан 27 мянган тонн улаан буудайг бас хүнсний улаан буудай авсан байна.

Одоогоор бол бас тэжээлийн үйлдвэрлэл нэлээдгүй тэгээд зуугаад мянган тонн улаан буудай бол тэжээлийн үйлдвэрлэлд ингээд шилжсэн. Энэ бол бас тэжээлийн зориулалтаар нэлээд борлогдож байгаа. Бид бүхэн бас түрүү 7 хоногийн 5 дахь

өдрийн мэдээгээр сонссон бол нийтдээ нэг 63 мянган тонн улаан буудай үтрэм дээрээ байна аа. Энэ бол нөгөө соёолсон будаанууд байна. Илүү нөгөө хайрагдсан, хорчгор ийм будаанууд байгаад байна аа.

Энийг бол илүү бас тэжээл үйлдвэрлэлийн зориулалтаар борлуулах чиглэл дээр бас бид бүхэн анхаарч бас Хөдөө аж ахуйн корпорац, тэжээлийн үйлдвэрүүдтэй гуравласан гэрээ байгуулаад худалдаж авах талд нь бас бид анхаарч ингээж ажиллаж байгаа. Мөн бас тодорхой хэмжээнд экспортод гаргах чиглэлээр нөгөө экспортын яриа хэлцлээр хийх чиглэлээр энэ ажлууд яриа хэлцлүүдийг хийж эхлүүлсэн ийм байна.

Гурилын үйлдвэр бас чанартай холбоотойгоор бас гурилын үйлдвэрт авсан будаа бас гурил үйлдвэрлэлийг чанаржуулах шаардлага байна гэсэн ийм улаан буудай бас импортлоор оруулж байгаа гэсэн ийм хүсэлтүүдийг бас нэлээдгүй бас тавьж байгаа ийм байна.

Ж.Батжаргал: Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар 2 дугаар микрофон.

У.Халиунаа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Хууль эрх зүй, дотоод хяналтын газрын дарга Халиунаа. Туваан гишүүний асуултад хариулъя аа.

Яг Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын хувьд бол албан ёсны монопол болон давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчийн үнэ бүрдэлтэд бол хяналт тавьж ажилладаг хуулийнхаа хүрээнд. Гэхдээ бид нар бол гурилын үнийг стратегийн хүнс гэдэг агуулгаар нь чухал Хүнсний тухай хуульд зааснаараа Монгол хүний

бие физиологиид зайлиггүй шаардлагатай хүнсний бүтээгдэхүүн гэдэг утгаар нь бол гурилын үнэд зайлиггүй бид нар үнэ бүрдэлтийн судалгааг бол жил тутамд хийгээд хяналт шалгалтыг хийгээд явж байгаа.

Хууль тогтоомжийн хувьд бол бид нар Зөрчлийн тухай хуулиараа яг тухайн яг зөрчилд нь таарсан торгох шийтгэлийг бол аваад явсан байгаа. Сая дурдсан яг Улаанбаатар хотод идэвхтэй тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа нийт массед, нийт иргэдэд одоо хүргэж байгаа дээд гурил болон 1 дүгээр гурил дээр нь хяналт шалгалтаа хийгээд Улаанбаатар гурил, Од групп 2-ыг бол харилцан үнээ хэлэлцэн тогтоож картель хийсэн гэдэг үндэслэлээр бол Зөрчлийн тухай хуульд заасны дагуу борлуулалтын 6 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгосон ийм асуудал.

Энэ маань шүүхийн шатанд явж байгаа учраас бас дэлгэрэнгүй бас мэдээлэл өгөх нь бас боломжгүй байна гэж үзлээ.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгчихье.

Д.Довчинсүрэн: Туваан гишүүний асуултад хариулъя.

Бид сая зөвхөн дээд гурил болон 1 дүгээр гурил дээр хийсэн судалгааныхаа ажлыг танилцуулсан. Хивэгний асуудал болон жил болгон өвөлжилтийн бэлтгэл өвлийн цаг агаарын нөхцөл байдал хүндэрлээ гэдэг асуудлаар бас тодорхой хэмжээний судалгаануудыг хивэг болон өвс тэжээлийн байдал дээр хийдэг ээ. тэгээд манай орон нутагт 16 аймагт улсын байцаагч ажиллаж байгаа. Энэ 7 хоногоос эхлээд Дорнод, Сүхбаатар аймгаас эхлээд бид нар манай орон нутаг дахь байцаагч нар өвөлжилт хүндэрч байгаа учраас удирдамж

боловсруулаад орон нутгийнхаа Тамгын газар танилцуулаад судалгааны ажил бол эхэлчихсэн явж байна. Энэ 2 аймгаас ямар ч байсан эхэлчихсэн явж байна. Тэгээд тодорхой энэ судалгааны үр дүнг үзэж байгаа зүйлд цаашид хяналт шалгалтын ажлыг бас хийж ингэж ажиллах ийм төлөвлөгөөтэй байгаа.

Яг одоогийн байдлаар өнөөдөр яг хивээг дээр хийсэн судалгаа байхгүй байна.

Ж.Батжаргал: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Тэр нөгөө стратегийн нөөц, улсын нөөцийн мэдээг Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан өгөөдхөөч.

Хоёрдугаарт энэ хүнсний газрын дарга оролцож байгаа гурилын чанар яг ямар байгаа юм? Иргэд энэ жилийн гурил ер нь урсац ихтэй маш тийм цавуулаг муутай байна гэж яриад байгаа юм. Сая ч бас тэр нэг гурилын үйлдвэрүүдийн хэрэгцээ гээд импортын хэрэгцээ гээд хүсэлтүүд өгч байгаа юм байна шүү дээ. Энэнтэй харахад энэ гурилын үйлдвэрүүд чинь гурил нь борлогдохоо болиод ирэхээр энэ чанаржуулагч байдлаар улаан буудай авах гээд байгаа юм биш үү? Энэ дээр та хэд маань ер нь ямар судалгаа юм хум байна.

Энэ 2 дээр нэг хариулт өгчхөөч.

Экспорт дээр та хэд ерөөсөө судалж байна, судалж байна л гээд байгаа. тэгээд чухам хэзээ ахиц гарах юм? Энэ улаан буудайн үлдэгдэл ихтэй болоод ирэхээр нөгөө тариаланч гурилын үйлдвэр аль аль нь хүндэрчихдэг шүү дээ. Энэ асуудлаа бас ер нь хурдавчилбал яасан юм бэ? Тэгээд асуултдаа тодорхой хариулт авчихъя.

Ж.Батжаргал: Хариулъя ажлын хэсгийн 1 дүгээр микрофоныг өгье. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Довчинсүрэн хариулт өгөөрэй.

Д.Довчинсүрэн: Сайн байцаана уу? Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хүнсний үйлдвэрийн Бодлого, зохицуулалтын газрын дарга Довчинсүрэн байна. Энэ улаан буудайн гурилын өртөг үнийн талаарх Монгол Улсын хэмжээнд 2023 оны намрын ургацаас болохоор энэ гурилын үйлдвэрүүдэд нийт 189 тонн мянган тонн хүнсний улаан буудай худалдан авсан бөгөөд одоогийн байдлаар 172.5 мянган тонн хүнсний улаан буудай, 14.4 мянган тонн гурилын нөөцтэй байгаад байгаа юм. Гурилын хувьд яг энэ өчигдөр бид нар бас улсын онцгой комисс дээр гурилын үйлдвэрүүдтэй бас уулзалт хийсэн. Гурилын холбоотойгоо бас уулзалт хийсэн. Тэгээд эд нарын бас нөгөө тавьж байгаа бас саналууд нь болохлоор гурил нэлээн чанаргүй. Саяын нөгөө Есөн-Эрдэнэ даргын хэлдгээр бас нэг тэрүүн дээрээ соёлолт энэ тэр гээд асуудлууд бас үүсчихсэн.

Улаан буудайн дээр бас үүссэн асуудалтай холбогдуулаад чанаржуулагч улаан буудай.

Ж.Батжаргал: Нэгдүгээр микрофоныг нэмээд өгчихье.

Д.Довчинсүрэн: Гэсэн хүсэлтийг бол тавьж байгаа. Тэгээд ирэх 7 хоногт Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл хуралдана. Энэ зөвлөл дээрээ яг энэ асуудлууддаа яригдаад тэгээд хэдий хэмжээний тоо чанаржуулах улаан буудай оруулж ирэх вэ гэсэн асуудлууд яригдаад явж байгаа байх аа? Тэгээд энэ экспортын асуудал болохоор БНХАУ руу бид нар 12 аж ахуйн нэгжийг бүртгүүлсэн байгаа.

Тэгээд протоколоо бас нэлээн тохирчихсон байгаа. Тэгээд яг экспортод гаргах болохоор Хятад улсын импортын татвар нь болохлоор яг нэг стратегийн бүтээгдэхүүн гэдэг дээрээ 65 хувийн татвартай байдаг юм байна лээ. Тэгээд тийм учраас бас яг Засгийн газрын хэмжээндээ бас яриа хийж л байгаа. Тэгээд яг улсын үйлдвэр нь тэндээсээ бас худалдан авалт хийе гээд код аваад ингэх юм бас 65 хувийнх нь татвар нь бас багасах тийм мэдээлэл ирчихсэн байгаа. Тэгээд энэ талаар л судалгааны шатандаа л явж байгаа даа.

Технологийн нөөц гэж технологийн нөөц, стратегийн нөөц гээд Хөдөө аж ахуйн корпорацид өнөөдрийн байдлаар нийтдээ 27.9 мянган тонн хүнсний улаан буудай авсан ийм нөөц юутай байна. Мөн нийтдээ 233 иргэн, аж ахуйн нэгжүүдээс 27.9 мянган тонн улаан буудай авсан нөөцтэй.

Ж.Батжаргал: Баярлалаа. Энхтүвшин гишүүн асуултаа асууя. Энхтүвшин гишүүний микрофоныг өгөөрэй. Асуулт асуух гишүүдийн нэрсд Аубакир гишүүний нэрийг нэмээд оруулчихъя.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Ер нь шалгалтын дүнтэй бас танилцлаа. Ингээд шударга өрсөлдөөний газраар шалгасан шалгалтын дүнг бас харж байна. Тэгээд ер нь өвөлжилт нэлээн хүнд болох нь, маш л хүнд л байна даа. Энэ хөдөө орон нутаг дээр. Тэгээд яаж энэ тэжээлийнхээ үнийг тогтвортой бас барих вэ. Тэжээлийнхээ үнийг яаж бууруулах вэ? Улсын нөөцийн тэжээлийг яаж бүрдүүлэх вэ гэдэг энэ асуудал дээр онцгой анхаарах хэрэгтэй байна.

Манай Хүнс, хөдөө аж ахуйн газар, яам. Тэгээд бид нар яг стратегийн хүнс гээд л их олон жил

ярилаа шүү дээ. Тэгээд одоо энэ ард иргэд маань үнэтэй гурил хэрэглэдэг. Малчид маань үнэтэй тэжээл хэрэглэдэг. Тэгээд стратегийн хүнс гээд л ингээд яваад байх юм уу энэ чинь. Бид нар ард иргэдээ бодох хэрэгтэй байна шүү дээ. Ард иргэдээ. Ард иргэд маань яагаад ингээд үнэтэй гурил хэрэглээд байгаа юм? Яагаад үнэтэй ийм тэжээл хэрэглээд байгаа юм гэдэг дээр та бүхэн маань нэг энэ хяналт шалгалтынхаа дүгнэлт дээр бас тодорхой бичмээр байна шүү дээ.

Цаашид авах арга хэмжээний тухай гээд биччихсэн. Тэгээд үнэ тогтворжуулах хөтөлбөр эд нар гээд нэг янз янзын банкны зээлтэй холбоотой асуудал биччихсэн. Тэгээд гурилын үнийг яаж бууруулах юм? Үгүй энэ Оросын холбооны улсаас орж ирж байгаа тэр импортын татвар болон нэмэгдсэн өртгийн албан татварыг нь тэглэх л дээ. Тийм санал яагаад оруулж ирж болохгүй байгаа юм. Тэгээд энэ ОХУ-аас орж ирж байгаа тэжээлийн импортын болон энэ гаалийн татвар, нэмэгдсэн өртгийн албан татварыг бууруулъя л даа.

Яагаад энэ хэдхэн энэ аж ахуйн нэгж байгууллага тариаланчдад зориулж ийм шалгалт хийгээд байгаа юм. Эцсийн эцэст энэ Монгол Улсын ард иргэд маань үнэтэй, хямд үнэтэй тэжээл хэрэглэх ёстой малчид маань хямд үнэтэй л гурил хэрэглэх ёстой биз дээ. Тэгээд яагаад ийм саналыг оруулж ирж чадахгүй байна. Шударга өрсөлдөөний хэрэглэгчдийн газар. Энэ гадуур хүн болгон л ярьж байна шүү дээ. Гурилын үнэ нэмэгдээд байна. Энэ импортын татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараа бууруулдаггүй юм байх даа гэдэг асуудал ярьж байна.

Тэжээлийн хомсдол бий болчихсон байж байна. Энэ тэжээлийнхээ гаднаас орж ирж байгаа

энэ бололцоо боломжийг нь яагаад нээж өгөхгүй байгаа гэдэг дээр яагаад ингээд дүгнэлтүүдийг оруулж ирэхгүй байгаа юм бэ? Ийм дүгнэлт орж ирэх болов уу л гэж бодсон юм. Тэгээд яагаад энэ асуудлыг оруулж ирээгүй вэ? Ямар учраас юу гэдэг юм энэ тэжээлийн үнийг бууруулах, гурилын үнийг бууруулах гээд цаашидаа ер нь бид нар энэ зах зээлийнх нь журмаар явбал яасан юм? Энэ дүгнэлтийг яагаад оруулж ирээгүй юм. Бид одоо улаан буудайныхаа хэрэгцээг юу гэдэг юм. Монгол Улс хангаж дийлэхгүй байна шүү дээ. 436 мянган тонн улаан буудай тариалсан. Үүний бараг 150-аас 200 мянга нь чанаргүй улаан буудай гарсан гээд. Тэгээд энэ гурилын үйлдвэрийнхээ хэрэгцээг хангаж чадахгүй байна шүү дээ.

Үгүй энэ чинь харин Үндэсний аюулгүй байдал юм биш үү? Яагаад тэгээд энэ улаан буудайг гаднаас оруулж ирэх энэ нөхцөл бололцоог нь бий болгож өгөхгүй байгаа юм. Яагаад энэ чанаргүй байгаа 150 мянган тонн улаан буудайг чанаржуулах ийм чанартай улаан буудайг оруулж ирэх ийм дүгнэлт яагаад байхгүй байгаа юм. Тэгээд ийм шалгалт хийдэг, ийм цаашид авах арга хэмжээ гэж ийм юм бичиж ирдэг ийм байгууллага байж болохгүй л дээ.

Ер нь Улсын Их Хурлын байнгын хороогоор нэлээн тооцоо судалгаатай ийм юм оруулж ирэх юм болов уу гэж би бодсон. Яг энэ чанаргүй улаан буудайг чанаржуулахад хэдэн тонн улаан буудай хэрэгтэй болчихоод байгаа юм. Гаднаас авах шаардлагатай юм. Энэ гурилын импортын болон нэмэгдсэн өртгийн албан татварыг тэглэх юм бол гурилын үнэ хэдэн төгрөгөөр буурах бололцоо боломж байгаа юм.

Энэ дээр тодорхой хариулт хэлээдэх л дээ. Энэ дээр яагаад ингээд тодорхой бичиж болдоггүй юм. Зөвхөн

гурилын үйлдвэрүүдийг шалгачхаад. Яагаад Монгол Улсын иргэн.

Ж.Батжаргал: Хариулт Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Ж.Батжаргал: Судалгааны явцад бид бас энэ импортоор оруулж ирж байгаа асуудлыг бас тодорхой хэмжээнд судалж үзсэн. Тэгээд улаан буудай нь бол стратегийн гол нэрийн бүтээгдэхүүнүүд бол Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн шийдвэрээр тухайн жилийн ургацын хэмжээнээс шалтгаалан импортын хэмжээг тогтоодог юм байна лээ.

Тэгээд 2023 оны хувьд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын шийдвэрээр нийт 8560.5 тонн үрийн улаан буудай, 50 мянган тонн хүнсний улаан улаан буудай импортлох ийм зөвшөөрлийг бол олгож ажилласан байдаг юм аа. Тэгээд яах вэ бид нарын гол фокуслаж шалгасан асуудал бол ер нь энэ бодлогын хувьд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ. Нэн ялангуяа энэ нөгөө Засгийн газрын эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд бол энэ олгож байгаа хөнгөлөлттэй зээлийн хүрээнд бас нэлээн ач холбогдол өгч ингэж шалгасан байгаа юм аа.

Ж.Батжаргал: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман, 1 дүгээр микрофон.

Д.Есөн-Эрдэнэ: Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Есөн-Эрдэнэ.

Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Энэ чанаржуулах зорилгоор бас улаан буудай бас импортоор авах гэж

байгаа. Квот өгөх гэж байгаа юу гэдэг талаар бас ярьж байна. Энэ дээр бол бас бид нар тооцоо судалгаа хийгээд жил болгон бол бас энэ улаан буудайн баланс, гурилын баланс гарсны дараа тодорхой хэмжээний улаан буудайг импортоор авах ийм квотыг Хүнсний аюулгүй байдлын зөвлөлд энэ саналыг оруулдаг байгаа. Энэ саналыг бид бүхэн бас бэлдээд ингээд ажиллаж байна.

Энэ 7 хоногтоо бол бас энэ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд энэ юуг оруулна. Бас тодорхой стратегийн хүнс болох гурил, улаан буудай, усны импортын квотыг оруулахаар ингээд бэлтгэл ажил бас ингээд хангаад ажиллаж байна. Бас тодорхой хэмжээний чанаржуулах зорилгоор улаан буудай оруулж ир гэсэн ийм хүсэлтүүд бол гурилын үйлдвэрүүд нэлээдгүй тавьж байгаа.

Ж.Батжаргал: Энхтүвшин гишүүн тодруулъя. Энхтүвшин гишүүний микрофоныг өгөөрэй.

Т.Энхтүвшин: Ер нь тэгээд манай Хүнс, хөдөө аж ахуйн яам цаашидаа анхаарах хэрэгтэй дээ тэгээд. Ер нь л энэ тэжээлийн үнийг өсгөж байгаа, гурилын үнийг өсгөж байгаа бол үндсэндээ та хэдийн барьж байгаа л бодлого шүү дээ. Хүн болгон л ярьж байгаа шүү дээ. Ер нь бид нар нэг ард иргэдээ нэг хямд үнэтэй гурилаар хангах ийм бололцоо боломжтой улс шүү дээ.

Тийм учраас цаашидаа бол энэ зах зээлийнх нь журмаар л явах хэрэгтэй шүү. Зах зээлийнх нь журмаар. Өнөөдөр Монгол Улсын иргэд маань хямд үнэтэй гурил хэрэглэх ёстой, малчид маань хямд үнэтэй тэжээл хэрэглэх ёстой гэдэг дээр л байр сууриа илэрхийлж яваарай та хэд маань. Хэдэн газар тариалангийн компани уначих гээд байна малчид маань юу гэдэг юм өндөр үнэтэй тэжээл иргэд маань өндөр

үнэтэй гурил хэрэглэх ёстой гэсэн ийм байр суурийг бас барьж болохгүй шүү. Та хэд тэгээд энэ юм ингээд нэг зах зээлийн журмаараа явахгүй болохоороо л ингээд л нэг доголдол гардаг юм л даа.

Жилийн жилд л дандаа энэ гурилын асуудал, тэжээлийн асуудал, өвс тэжээлийн асуудал.

Ж.Батжаргал: Энхтүвшин гишүүний микрофоныг нэг минутаар үргэлжлүүлж өгье.

Т.Энхтүвшин: Тэгээд бодлогын яам танайх. Одоо бодлого биш танайх аж ахуйн үйл ажиллагаанд оролцдог гүйцэтгэлд нь хяналт тавьдаг, хяналтаа авчихсан, бүүр тийм яам болсон шүү дээ. Бодлого хэрэгжүүлэхээс гадна аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд шууд оролцдог, шууд хяналт тавьдаг ийм яам болчихсон шүү дээ.

Тийм учраас та хэд бол ердөө дээрээс нь доод хүртэл нь бүх юмыг харж байгаа учир энэ асуудлыг цаашидаа энэ зах зээлийнх нь журмаар явуулах гурилын үнийг буулгах, тэжээлийн үнийг буулгах энэ асуудал дээр онцгой анхаараарай. Стратегийн хүнс гэж ярьсаар байтал одоо юу гэдэг юм. Наад малчид маань иргэд маань нэлээн хүндэрч байна шүү. Баярлалаа.

Ж.Батжаргал: Баярлалаа. Санал хэллээ. Одоо Мөнхцэцэг гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхцэцэг: Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөөх газрын энэ шалгалтын дүн, тайланг бас сонсож байна. Тэгэхээр энэ улаан буудайн үнэ 26.4 хувиар өссөн боловчиг нэг удаа килограмм тутамд гурилын үнэ 52.3 хувиар ингээд өссөн гээд ингээд та бүхэн маань бас ийм дүгнэлт гаргаад ирсэн юм байна л даа.

Тэгэхээр ер нь гурил үйлдвэрлэгчид үндсэндээ үндэслэлгүй нэмсэн гэсэн ийм дүгнэлтийг өгч байгаа юм байна. Тэгэхээр яг энэ бас гурил өссөнтэй холбогдуулаад хөдөө орон нутагт байж байгаа одоо бас яг энэ худалдан авагчид маань илүү их нэмүү өртөг шингэсэн ийм гурил бас худалдаж авч хөдөө орон нутагт бас байдал хүнд байна л даа. Гурилан бүтээгдэхүүнүүд өссөн байна. Зүгээр зөвхөн одоо ингээд говийн бүс Дундговь ч гэдэг юм уу энэ аймгууд дээр ингээд л үзэхэд 1 дүгээр гурил гэхэд өнөөдөр Улаанбаатар хотод 2400 орчим төгрөг байж байхад яг говийн бүс хөдөө орон нутагт 2770 гараад явчихсан байж байгаа юм.

Тэгэхээр 1 уут гурилаас үндсэндээ 300-аас 400 орчим төгрөгийн зөрөөтэй. 2 дугаар гурил гэхэд мөн адилхан. Улаанбаатар хотод 1600 орчим байж байхад хөдөө орон нутагт 2200 гараад явчихсан. Үндсэндээ ингээд дундаас нь 800 төгрөгийн бас ийм зөрөөтэй байх жишээний. Ийм их зөрөөтэй худалдан авалтыг хөдөө орон нутагт хийж байна л даа.

Тэгэхээр яалт ч үгүй ард иргэдийн бухимдаж байгаа бол мэдээж ойлгомжтой. Ийм их зөрөөтэй бас гурил худалдаж авч байна гээд. Тэгээд юу хэлдэг вэ гэхээр манай ер нь говийн нөхцөлд тэртээ тэргүй бас үр тариад байх боломж байхгүй. Төмс хүнсний ногооныхоо нийт хэрэглээнийхээ 21-хэн хувийг л хөдөө орон нутагтаа тариалалтаас ингэж хангаж байх жишээний. Тэгээд ирэхээр би Хөдөө аж ахуйн яамнаас энэ асуултыг асуух гээд байгаа юм.

Энэ гурил ингээд өсөөд байна. буух ямар боломж байгаа юм бэ гэж. Өссөн шалтгаан нь юундаа байгаа юм бэ бас? Тийм энэ дээр та бүхэн ямар бодлого цаашид авч хэрэгжүүлэх юм.

Шалгах ёстой газрууд нь шалгаад ингээд дүгнэлт гаргаад ирсэн байна. Буцаад ямар хариу арга хэмжээ авах юм бэ? Буулгах бололцоо нөхцөлүүд нь байгаа юм уу, үгүй юм уу? Ер нь бас яг энэ аж ахуйн нэгжүүд компаниуд бол ямар зүйлийг ярьдаг вэ гэхээр ялангуяа энэ жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж байгаа хүмүүст зээлийн бодлого хөнгөлөлт гэдгийг огт Хөдөө аж ахуйн яам бодлогоор хэрэгжүүлэхгүй байна аа.

Ийм учраас том монопол болсон энэ компаниудад энэ хөнгөлөлттэй зээлүүдийг олгочихдог учраас жижиг энэ үйлдвэрлэл эрхэлж байгаа бидний хувьд их хүндрэл учирч байна. Энэ зээлийн бодлогодоо Хөдөө аж ахуйн яам анхаарах хэрэгтэй байна гэдэг ийм зүйлүүдийг бас аж ахуйн нэгжүүдээс ирдэг. Хөдөө орон нутгаас тавьдаг.

Тэгэхээр энэ зээлийн бодлогод ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх гэж байгаа юм? Дээрээс нь энэ өссөн үнийн өсөлтийг бууруулах бололцоо нөхцөл байна уу, үгүй юу? Хөдөө аж ахуйн яамнаас асууж байна?

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам.

Д.Есөн-Эрдэнэ: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Есөн-Эрдэнэ. Улаан буудайны үнэ бас энэ тээвэр ложистик бусад бусад улс орнуудад байх ёстой энэ геополитикийн асуудалтай холбоотойгоор бас үнэ тодорхой ингээд олон улс дээр ч гэсэн бас нэмэгдсэн. Мөн манай улс бол ихэнх орцуудыг шатахуун, бордоо, урвал хамгааллын бодис, техник, сэлбэг гээд бүх ийм орцуудыг бол импортоор авдаг

ийм байгаа. Тэгээд үндсэндээ бол хөрс ажиллах хүчин 2 л манай дотоодын хамааралтай.

Бусад нь бол гадаад зээл зах зээл нөхцөлийн хамааралтайгаар улаан буудайны өөрийн өртөг яах аргагүй өсөөд байгаа юм. Тэгэхээр энэ нөхцөл дээр бол бас тодорхой бас ажлуудыг Засгийн газраас бас авч хэрэгжүүлээд бодлого хөнгөлөлттэй зээл олгох зэрэг энэ яг хийсний үр дүнд бол бас энэ тодорхой хэмжээний энэ тариалалт хийгээд дотоодын хэрэгцээг хангахуйц бас хэмжээний ийм улаан буудай, ургац хурааж авсан ийм байгаа.

Тэгэхээр энэ цаашидаа бол яг энэ үнийн асуудал бол энэ гадаад зах зээлээс илүү хамааралтай ийм байгаад байгаа гэдгийг бас хэлэх байна. Мөн гурилын үйлдвэрүүд бас ялгаагүй бас тээвэр ложистик улаан буудайн үнэ, нийт гурилын үнийг үйлдвэрлэдэг 79.3 хувь нь бол улаан буудайн үнээс хамааралтайг ийм гурилын үйлдвэрүүд хамаардаг. Дээр нь болохоор ингээд тээвэр ложистик, хүн цалин хөлс, сэлбэг, тоног төхөөрөмж, энэ валютын үнэ хани гээд энэнтэй холбоотойгоор бас үнэ өссөн гэсэн ийм дүгнэлтүүд хүрч байгаа. Энэ нь бол өнгөрсөн жилтэй харьцуулахад бол ингээд 8-аас бас 23 хувийн ийм өсөлттэй ийм байгаа гэж.

Тэгэхээр энэ цаашидаа бол үнийн өсөлтийг олоход мэдээж бол ийм хөрсний үржил шимийг сайжруулах, нэгжээс авах ургацын хэмжээг сайжруулах энэ асуудлууд бас чухал. Тэгэхээр хөрсөө хамгаалах асуудлууд бас чухал байна. Дээр нь болохоор бол бас улаан буудайнд татаас.

Ж.Батжаргал: Бас ингэж яримгүй л байна. Наад мэргэжлийн байгууллага чинь шалгаад 7 сард танайд шалгалтын материалаа албан ёсоор хүргүүлчихсэн юм байна шүү дээ.

Тэднийхээр гарсан дүгнэлт нь үндэслэлгүй байх үндэс байна гээд хэлчихсэн байна шүү дээ. Тэгээд та хэд ямар арга хэмжээ юу авсан юм тэрийгээ л их тодорхой хэлчхээч дээ.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нэмээд хариулаадаа даа. Тэгж байгаад чи нэмээд тодруулга хий. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Ч.Однасан: Ер нь яах вэ олгож байгаа зээлийг олгож дэмжлэг нэлээн үзүүлж байна аа. Тэгээд ингээд дэмжлэг үзүүлээд гэрээг байгуулчхаад байхад аж ахуй эрхлэгчид үнээ нэмээд байна аа. Тэгэхлээр энд бол яах вэ гэрээнийхээ заалт дээр үнийг тогтвортой байлгана гэсэн ийм гэрээний заалт байгаа юм. Тэгэхээр энэ гэрээний хэрэгжилт хангалтгүй байна аа. Энэ дээр тодорхой түвшинд анхаарах ийм шаардлага байна. Тэгээд энэ дээр яах вэ энэ гурил үйлдвэрлэгчид олгож байгаа хөнгөлөлттэй зээлд бол яг энэ үйлдвэрлэгчид тодорхой хэмжээний үр дүн өгөхгүй байгаа энэ нөхцөлд тариалан эрхлэгч нэн ялангуяа тэр жижиг тариалан эрхлэгчдийг хөдөө орон нутагтаа дэмжиж ажиллавал яасан юм бэ гэсэн ийм л дүгнэлтийг Хөдөө аж ахуйн яаманд хүргүүлсэн.

Ж.Батжаргал: Гүйцээгээд хариулчих. 2 дугаар микрофоныг нэмээд өгчих дөө.

Ч.Однасан: Жил болгон Хөдөө аж ахуйн сайдын шийдвэрээр бол нөгөө улаан буудай хүнсний улаан буудайг бол худалдан авах үнийг бол тогтоодог юм байна лээ. Тэгэхээр энэ тогтоож байгаа юм бол бас жилээс жилд өсөөд байна. Энэ дээр бас анхаарах ийм шаардлага байна л гэсэн ийм л дүгнэлтүүдийг хийсэн байгаа юм.

Ж.Батжаргал: Мөнхцэцэг гишүүн тодруулъя.

Г.Мөнхцэцэг: Энэ ингээд тайлан дээр биччихсэн тайлбарыг буцаагаад ирүүлээд хэлээд байгааг чинь бас ойлгохгүй байгаад байна л даа Хөдөө аж ахуйн яам.

Тэгэхээр ер нь бол ингээд тэртээ тэргүй наад шалгалтын чинь дүнгээр энэ ингээд ийм ийм нөхцөл байдлууд үүссэн учраас та нар ийм ийм зүйлүүдийг авч хангаж ажиллахгүй байгаа учраас энэ үнийн өсөлтөд чинь нөлөөлж байна гээд ингээд тодорхой хэмжээний бүүр ингээд гаргацтай бичээд хэлээд өгчихсөн байна шүү дээ. Тэгээд ирэхээр харин бид нар та нар цаашид бид ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх юм бэ гээд асуугаад байгаа байхгүй юу? Энэ 7 сард хийчихсэн шалгалтынхаа дүнг цаашаа энэнээс хойш ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх гэж байгаа юм. Одоо хүртэл ингээд бодлого нь тодорхой биш. Энэ үнийн өсөлтийг яаж бууруулах тухай ямар ч гарц гаргалгаа хайгаагүй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энийг асуугаад байгаа юм.

Тэгээд энэндээ хариулт өгчхөөч гэсэн ийм бүрхэг хариулт өгөөд байх юм. Тэгээд ер нь бол яг энэ хөнгөлөлттэй зээлийг хэчнээн аж ахуйн нэгжид олгосон юм. Томоохон компаниуд тодорхой угаасаа авчихсан байгаа нь тодорхой. Аваад ингээд иргэд үйл ажиллагаагаа болгоод явж байгаа нь тодорхой. Жижиг аж ахуйн нэгжүүдэд яаж олгох юм? Яг амьдрал дээр хөрсөн дээр.

Ж.Батжаргал: Мөнхцэцэг гишүүний микрофоныг нэг минутаар сунгая.

Ц.Мөнхцэцэг: Хөдөө орон нутагт ер нь яалт ч үгүй бас нэг жижиг

л үйл ажиллагаа явуулдаг ийм аж ахуйн нэгжүүд л энэ чинь талх тариагаа хийгээд л ингээд л амьдралаа залгуулаад явж байгаа шүү дээ. Тэд нар чинь байнга л бид нар бас нэг ийм зээл тусламж хүсэж байгаа. Ийм хүсэлтүүдийг бидэнд бас ирүүлээд байдаг. Тэд нарт олгодоггүй зээл том том компаниудад олгогдоод ингээд явчихдаг хэрнээсээ буцаад ингээд үнээ нэмээд байдаг, бүтээгдэхүүнийхээ үнийг нэмээд байдаг. Дагаад ингээд гол түүхий эдийнхээ үнийг нэмээд байдаг.

Тэгэхээр энэ дээр яам яагаад ингээд бодлого болгоод ингээд авч хэрэгжүүлэх арга хэмжээндээ тусгадаггүй юм бэ гэдэг зүйлийг л би асуугаад байгаа юм л даа.

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон. Есөн-Эрдэнэ дарга.

Д.Есөн-Эрдэнэ: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Засгийн газраас бас энэ хүнсний хангамж аюулгүй байдал, үндэсний хөдөлгөөний хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид зориулаад бас хөнгөлөлттэй зээл, арилжааны банкттай хамтраад хөнгөлөлттэй зээл олгож байгаа.

Засгийн газраас хүүгийн хөнгөлөлтийг үзүүлж байгаа. Энд бол нийтдээ энэ жилийн тухайд нийтдээ 645 иргэн, аж ахуйн нэгжид 89.7 тэрбум төгрөгийн төмс болон үр тарианы аж ахуй эрхлэгч 645 иргэн аж ахуйн нэгжид 89.7 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. Жимс хүнсний ногооны тариалан эрхлэгч 559 иргэн аж ахуйн нэгжид 24.3 тэрбум төгрөгийн ийм зээлийг одоогоор бас олгоод байна. Мөн хөрөнгө оруулалтын чанартай зээлийг 171 иргэн аж ахуйн нэгжид 5 жилийн хугацаатай, 6 хувийн хүүтэй.

Ж.Батжаргал: Бейсен гишүүн асуулт асууя. Бейсен гишүүний микрофоныг өгөөрэй.

Б.Бейсен: Энэ эрүүл мэндээ хамгаалах, эдийн засгаас сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний дагуу 2021 онд нийтдээ 38.4 тэрбум төгрөгийн, 2022 оны 2 удаагийн 81.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон Хөдөө аж ахуйн байгууламж. Гэтэл гурилын үнэ өссөн. Хөдөөд бараг 2 дахин өссөн. 67 мянга байсан нэг шуудай гурил чинь одоо 120-125 мянга. Хөдөө сумууд дээр бүүр 130, алслагдсан газар 140, нөгөө тээврийн зардлаа нэмээд. Энэ хөнгөлөлттэй зээл авчхаад гурилын үнэ ингээд нэмчихсэн. Ноднин зуд болсон. Энэ жил бас зудын байдалтай. Ялангуяа баруун аймаг дотроо энэ жил зуншлага муу болсон. 9 сарын сүүл, 10 сарын эхээр одоо зарим газар 50 см зузаантай цас орсон. Өвөлжөөнд 10 сард орсон малчдын байдал хүнд байгаа. Ноднингийн зээлээсээ салаагүй байгаа. Гэтэл энэ хил орчмын байгаа аймгууд дээр Ховд, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай ч юм уу. Малын тэжээлийн үнэ өндөр байна.

Энэ гааль, импортын татварыг чөлөөлөх НӨАТ-ыг чөлөөлөх боломж бий юу? Ер нь энийг шалгаж үзсэн үү? Нөгөө талаар хил орчмын аймгийн сум багийнхан хилийн худалдаа хийдэг. Цаад талд нь Оросоос 1 шуудай гурил 45-аас 55 мянган төгрөгийн хооронд байгаа. Гэтэл энийг одоо Хүнс хөдөө аж ахуйн яам, Гаалийнхан хилийн худалдаа хийж байгаа улсуудын нэг шуудай гурилыг ч хүртэл нэвтрүүлэхгүй хурааж авч байгаа. Энийг танай яам яасан уу, гаалийнхан нь хийж байгаа ажил уу? Энийг шалгаж үзсэн үү? Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн газар энийг бас хяналт тавьж үзэх хэрэгтэй байна.

Энэнтэй холбоотой энэ гурил хэл орчмын энэ жил чанаргүй будаа хурааж

авсан гэж тэгж байна бараг 30 хувь нь чанаргүй будаа гээд ярьж байна сая Туваан гишүүн. Энэнтэй холбоотой тэр гурилын импорт НӨАТ-ын асуудал тэр хил орчмын орж байгаа тэр малын тэжээлийн асуудлыг бууруулах боломж бий юу? Ер нь энэ талаар асууя.

Ж.Батжаргал: Хариулъя Хөдөө аж ахуйн яам эхлэх үү? Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Үнийн талаарх юунаас хариулъя Есөн-Эрдэнэ дарга.

Д.Есөн-Эрдэнэ: Бейсен гишүүний асуултад хариулъя.

Энэ дээр бол манайх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас улаан буудайн л квот олгож байгаа. Бусад юун дээр бол энэ хязгаарласан зүйлүүд бол байхгүй хуулиараа бол. Тэгээд улаан буудайн гурил дээр бол баяжуулсан гурилыг бол нөгөө хүнсний үйлдвэрлэлд баяжуулсан гурил хэрэглэх, ийм Баяжуулсан хүнсний тухай хууль байгаа. Энэ хүрээнд бол бас гурилын үйлдвэрлэл бол баяжуулсан гурил, импортоор оруулж ирэхэд баяжуулсан гурилын хэрэг шаардлагатай гэсэн ийм л шаардлагуудыг бас тавьж байгаа.

Тэгжээл дээр бас тодорхой хэмжээнд бас орж ирэхэд нь бол ямар нэгэн хориг байхгүй. Ийм байгаа. Энэ импортын татварын асуудал бол тарифын асуудал бол бас энэ Сангийн яамтай мөн бол энэ Сангийн яаман дээр Их Хурал дээр орж ирж шийдэгдэх асуудал байгаа. Энэ Их Хурлын бүрэн эрхийн асуудал гэж бодож байна.

Ж.Батжаргал: Бейсен гишүүн тодруулъя. Бейсен гишүүний микрофоныг өгөөрэй.

Б.Бейсен: Энэ 2021 онд нийт 3 удаагийн 38.4 тэрбум, 2022 онд 2

удаагийн 81.3 тэрбум 10-н их наядын хүрээнд.

Ийм хөнгөлөлттэй зээл авчхаад ингээд гурилын үнэ яагаад нэмэгдчихэв. Энэ дээр дүн шинжилгээ хийж үзсэн үү? Засгийн газраас хөнгөлөлттэй зээл өгөөд байдаг гурилын үнээ нэмчихдэг юм. Хөнгөлөлттэй зээл авчхаад, 1 дүгээрт.

Хоёрдугаарт ноднин тэр тэжээлийн асуудлыг ярьж байна. Энэ хойноос орохгүй бол ноднин манайд чинь нэг шуудай хорголжин чинь 80 мянга хүрсэн шүү дээ. Одоо 45 мянган төгрөгтэй байна. Энийг бууруулах асуудал дээр Хөдөө аж ахуйн яам Шударга өрсөлдөөний хэрэглэгчийн газар анхааралдаа авахгүй бол манайх чинь 6 сар хүртэл ногоо ургадаггүй шүү дээ. Зудын байдалтай байдаг. Баруун аймаг энэ дээр анхаарахгүй болохгүй нь ээ.

Ж.Батжаргал: Хариульа 1 дүгээр микрофон.

Д.Довчинсүрэн: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Довчинсүрэн. Бейсен гишүүний асуултад хариульа.

Энэ улаан буудайн өртөг гурилын өөрийн өртгийг бол 86.6 хувийг нь улаан буудай худалдан авах, тээвэрлэх, хадгалах зардал эзэлдэг учраас гурилын үнүүд улаан буудайн үнээс шууд хамааралтай байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр болохоор улаан буудайн өртөг шатах тослох материал нь 23.8 хувь, хөдөлмөрийн зардал нь 7.9 хувь, худалдан авах зардал нь болохоор 23.6 хувь, бордоо 11.5 хувь, Ургамал хамгааллын бодис 14 хувь бусад зардал буюу нөгөө техник сэлбэг хэрэгсэл гээд 19.2 хувийг тус тус эзэлсэн тийм тооцоо судалгаануудыг гаргасан.

Энэнээсээ шалтгаалаад бас нэг гурилын үнэ бас нэмэгдсэн юм шиг байгаа юм. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл 2022 онд хуралдаад бол 2022-оос 2023 онд оруулж ирэх гурилын тоо хэмжээн дээр хязгаар тогтоогоогүй. Тийм учраас яг ОХУ-аас орж ирж байгаа.

Ж.Батжаргал: Гүйцээгээд хариулчих.

Нэгдүгээр микрофоныг сунгаадаг даа. Ажлын хэсгийн.

Д.Довчинсүрэн: Орос талаасаа яг татварынхаа асуудлаасаа болоод яг орж ирэх тал дээр жсоохон энэ жилийн хувьд бол 8 мянган тонн орчим орж ирсэн байна лээ. Тэжээлийн хувьд ямар нэгэн тийм хориг саад бол байхгүй байгаа.

Ж.Батжаргал: Наад нэг баахан яриад байгаа өөрийн өртгийг бүрдүүлж байгаа зардлын чинь асуудал тариаланчид буюу тариаланчдаас гарч ирж байгаа бүтээгдэхүүний үнийн тухай л асуудал. Наад нөхдүүд чинь судалгаа юмнуудаа хийгээд буудайны чинь үнэ 26 аравны хэдээр нэмэгдсэн байхад гурилын чинь үнэ 52 аравны хэдээр өсчихлөө гээд ингээд тов тодорхой тоо хэлчхээд байна шүү дээ.

Тэгэхээр та хэд эргүүлээд нөгөө талд нь тоо яриад үймүүлээд ерөөсөө болж өгөхгүй юм. Наадах дээрээ л нэг тодорхой тайлбар хариулт өг л дөө.

Ж.Батжаргал: Идэрбат гишүүн асуулт асууя. Идэрбат гишүүний микрофоныг өгөөрэй.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнгөрсөн 7 хоногт бас байнгын хорооны хурал дээр энэ гурилын үнийн асуудалтай холбоотой асуудлыг Байнгын хорооны хурлаар оруульа гэж

ингэж санал гаргаад тэгээд манай Байнгын хороо бас идэвхтэй ингээд шуурхай ажиллаж байгаад бас баяртай байна. Ер нь өнөөдөр бид нар зөвхөн гурилын үнэ ярьж байгаа боловчиг энэ чинь Монголын зовлон болчихсон юмыг ярьж байгаа шүү. Зовлон болчихсон юм ярьж байгаа.

Хөдөө орон нутагт явахад энэ цалин, тэтгэврийн нэмэгдлүүдийг гол залгиж байгаа юм нь бол гурилын нэмэгдэл байна гэдэг дээр өсөлт байна гэдэг дээр иргэд ярьж байгаа юм. Бизнес эрхлэгчид зээл авах гэсэн зээлийн хүү өндөр байна гэж ийм зовлон ярьж байгаа юм. Энэ зээлийн хүү өндөр байгаагийн шалтгаан бол энэ гурилын үнэ шүү.

Тийм учраас энэ гурилын үнийн асуудлыг бас ингэж гаргаж ирж ярьж байгаа юм. Та бүхэн санаж байгаа бол 2022 онд Монголбанк төрийн мөнгөний бодлогын баримт батлуулахдаа инфляцад гадаад дотоод хүчин зүйл байна гээд бодлогын хүүгээ 13 дээр барьчихсан. 2023 онд арваадхан хоногийн өмнө бас энэ асуудал яригдахад бас инфляцын түвшин 2 оронтой тоонд байна аа. Ийм учраас бодлогын хүүгээ 13-аас буулгаж болохгүй байна гээд 13-аар баталчихсан.

Бодлогын хүү нь 13 хурчихээр орон нутагт бизнес эрхлэгч нар ер нь бизнес эрхлэгч нар жилийн 20-оос 24%-ийн хүүтэй зээл авч эхэлж байгаа юм. Тэгээд энэ чинь ганцхан гурилын үнийн асуудал биш байгаа юм гэдгийг хэлэх гээд байгаа юм. Монгол банкны мэдээлэл дээр ч тэр Сангийн яамны мэдээлэл дээр ч тэр гурилын үнийн өсөлт гэдэг бол дотоодын инфляцын нэлээдгүй бараг дөчөөд хувийг нь эзэлж байна гээд. Би та хэдэд энийг бүүр харуулъя.

Энэ Монголбанкны 2024 онд төрийн мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төсөл байгаа юм. Энэ дээр дотоодын нэн хэрэгцээтэй 20 бараа бүтээгдэхүүн үнийн өсөлтөд нөлөөлж байгаа юм. Үүний дотроос хүнсний 14 бүтээгдэхүүн байгаа юм. 14 бүтээгдэхүүн. Үүний дотроос хүнсний 14 дотроос 6 нь гурилтай шууд холбоотой байгаа. Энийг та бүхэн хараарай.

Энэ үнийн өсөлт нь дээд тал нь 51 хувиас 24 хувь хүртэл нөлөөлж байгаа байхгүй юу. Тийм учраас энэ гурилын үнийн өсөлт гэдэг зүйлийг хэн нэгнийг буруутгах гээд юм уу ингэх гээд байгаа юм биш. Дотоодын үйлдвэрлэгчдийг шахаад байгаа юм биш. Энэ чинь энэ Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа энэ цалин, тэтгэврийн нэмэгдэл энэ хамаг юмыг чинь залгиад байгаа юм.

Тийм учраас энэ гурилын үнийн асуудлыг оруулж ирж байгаа юм гэдгийг бас би зориуд хэлж байгаа юм. Тэгэхээр зүгээр нэг гурил яриад байгаа юм шиг нэг гурилын юм наана цаана яриад байгаа юм биш. Энэ чинь Монголын эдийн засагт Монголын бүх ард түмэнд нөлөөлөөд байгаа байхгүй юу. Тэгэхээр би энэ Хөдөө аж ахуйн яам, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрыг та нар зүгээр нэг гурил гэдэг юм ярихаасаа илүүтэйгээр Монгол Улсын эдийн засагтай холбоотой, инфляцтай холбоотой, дагаад бизнестэй холбоотой зээлийн хүүтэй холбоотой асуудлыг ярьж байгаа гэж ингэж ойлгоорой гэж би бүр зориуд хэлэхийг хүсээд байгаа юм. Тэгэхгүй та бүхэн ингээд нэг гишүүдийн асуултад зүгээр нэг аргалах маягтай ингээд 2 бие рүүгээ хийх маягтай ийм байдлаар хариулаад байгаад жоохон сэтгэл дундуур байна.

Ер нь одоо ингээд гурилын үнийн нэмэгдэх болсон шалтгаан ингээд

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар бол үндэслэлгүй нэмсэн байна гэж байна шүү дээ. Хөдөө аж ахуйн яам бол энэ дээр яг тодорхой хариулж чадахгүй байна шүү дээ та нар. 2023 оны 7 сард энэ чинь болохоо байлаа гээд өгчхөөд танайх ямар хариу үйлдэл хийсэн юм бэ? Энэ гурилын компаниудтайгаа уулзсан юм уу? Ярьсан юм уу? Та нарын эс үйлдэхүй чинь энэ Монголын эдийн засагт маш их чөдөр болж байгаа шүү. Энэ дээр одоо яг тэр Есөн-Эрдэнэ дарга байх аа. Та яг энэ гурил үйлдвэрлэгчдэдээ энэ Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрынхны өгсөн энэ шалгалтын материалын дүнгийн талаар уулзалтууд хийсэн үү гэдгийг та тов тодорхой хариулаач.

Хэрвээ уулзалт хийсэн бол хэзээ хийсэн. ямар үр дүнд хүрэх шийдэлд хүрсэн юм бэ? Одоо хэдүүлээ ингэж нэг нэгнийгээ аргалдгаа болиод яг бодитой юм яримаар байна аа.

Ж.Батжаргал: *Хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.*

Д.Есөн-Эрдэнэ: *Сайн байна уу? Идэрбат гишүүний асуултад хариулъя.*

Идэрбат гишүүнтэй бас санал нэгтэй байна аа. Гурил үйлдвэрлэгчдийн холбоогоор дамжуулаад гурил үйлдвэрлэгч нартай бүгдтэй нь уулзалтууд хийсэн. Яг тэд нартай уулзаад яг ямар шалтгаан нөхцөл дээрээс ингээд үнэ нэмэгдсэн бэ гэхээр яг түрүүний хэлдэг шалтгаануудыг л хэлдэг юм. Яг гадаад геополитикийн асуудлууд тэгээд энэ бензин тосны асуудлууд, тэгээд ер нь яг бас нэг яригдах нэг асуудал нь болохоор нөгөө хүний нөөцийн асуудлууд ерөөсөө байдаггүй. Тэгээд эд нарыгаа барихын тулд бас ийм асуудлууд үүсдэг. Тэгээд энэ улаан буудайн бас асуудлууд байна.

Нэг өндөр үнэтэй болсон энэ тэр гээд тэгээд улаан буудайны асуудал нь болохлоор бас л тэр нөгөө нэг бордоо ургамал хамгааллын бодис эд нар гээд эдгээр шалтгаануудаас болоод үнэ нэмэгдсэн энэ тэр гэсэн асуудлууд байгаад байдаг. Тэгээд яг энэ шалтгаануудыг л хэлж байгаа юм.

Бид нар уулзалтыг бол 3-аас 4 удаа хийсэн. Өчигдөр хүртэл Онцгой комисс дээр бас яг бүх гурилын үйлдвэрийнхэнтэйгээ уулзаж энэнээс хойш танайх үнээ өсгөх үү яг ямар шалтгаанаар тэр вэ. Энэ тэр гээд бүгдэнг нь ярьж шийдвэрлэсэн байгаа. Тэгээд тэднээс чанаржуулагч нэг улаан буудай оруулж ирээч бид нар энийгээ яаралтай авч эргэлтэд оруулмаар байна. Улаан буудайгаа өөр гурилаа эргэлтэд оруулмаар байна гэсэн асуулт тавьдаг. Үнийг ойрын хугацаанд нэмэгдүүлэхгүй л гэсэн санал тавьж байгаа юм.

Ж.Батжаргал: *Идэрбат гишүүн тодруулъя.*

Ц.Идэрбат: *Тэгэхээр ер нь бас нэг зарчмаа ойлгочихмоор байгаа юм даа. Яг ингээд үнийн өсөлтийн шалтгаан ийм байна гээд шалгах ёстой байгууллага нь шалгаад гаргаад ирсэн. Болохгүй байна гэдгийг нь гаргаад ирсэн. Тэгэхээр энэ дээр одоо тэгээд яг хэнийх нь үгэнд орж энэ төрийн байгууллага цаашаа үйл ажиллагаагаа явуулах юм бэ гэдгийг нь Хөдөө аж ахуйн яам 1 тайлбарлаж өгөөч.*

Хоёрдугаарт үнийн өсөлтийг явуулахгүй гэдэг энэ 2 талын тохиролцоо гэх үү хэлэлцээр гэх үү энэ зүйлүүд чинь тэр янз янзын хөнгөлөлттэй зээлүүдээр дамжаад одоо цаасан дээр буугаад амьдрал дээр хэрэгжээгүй гэдгийг энэ 2 жилийн хугацаанд харчихлаа шүү дээ. Тэгэхээр энэ татвар төлөгчдийн мөнгөөр энэ

баахан хөнгөлөлттэй зээл олгосон энэ асуудлууд зүгээр л хэн нэгэн биелээгүйгээс болоод ингээд 100 хэдэн тэрбум төгрөг ингээд л өнгөрөх үү? Энэ дээр Хөдөө аж ахуйн яам ямар бодолтой байгаа юм. Энийг асууя.

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам. Довчинсүрэн.

Д.Довчинсүрэн: Энэ үнийн өсөлттэй холбогдолтойгоор яг гурилын үйлдвэрүүддээ бас 3-аас 4 удаа уулзсан гэж түрүүн хэлсэн. Тэгээд энэнтэйгээ холбогдуулаад бас нөгөө хүнсний хангамж аюулгүй байдал, үндэсний хөдөлгөөний хүрээнд 36 дугаар тогтоолынхоо хүрээнд 5-6 хувийн зээлийг энэ гурилын үйлдвэрүүд болон мах гээд ер нь гол нэрийн 19 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа үйлдвэрүүд дээр олгож байгаа. Тэгээд энэ дээр бүгдэд нь бас л яг таны хэлдгээр шаардлагуудыг тавьж л явж байгаа.

Тэгэхээс яг энийгээ буулга гэсэн тийм шаардлагыг тавих эрх зүйн хувьд бас боломжгүй болчихоод байна л даа.

Ж.Батжаргал: Идэрбат гишүүн дахиж нэг тодруулъя. Идэрбат гишүүний микрофоныг.

Ц.Идэрбат: Тэгээд одоо энэ чинь зээл өгөөд буудаггүй. Хоорондоо гэрээ байгуулаад буудаггүй, гэрээ зөрчигдөөд байдаг. Тэгээд эцсийн одоо ер нь яг Хөдөө аж ахуйн яам энэ гурилын үнэ өсгөхгүй тал дээр яг энэ гурил үйлдвэрлэгчдээс төрийн зүгээс ийм юм чинь болохгүй байгаа учраас гурилын үнэ өсгөхөөс өөр аргагүй байна шүү дээ гэсэн тийм албан ёсны тайлбар юмыг нь сонсоод тэрний эсрэг хариу арга хэмжээ ийм юм авъя гэсэн ийм төлөвлөгөө та бүхэнд байна уу?

Уулзалтууд хийгээд 4 удаа уулзалт хийгээд үр дүн гараагүй юм байна гэж ингэж ойлголоо шүү дээ.

Тэгэхээр бодлого барьж байгаа яамны хувьд бол үнэхээр энэ Монголчуудын хоногийн хэрэглээний 63 хувь нь гурилтай холбоотой байдаг юм байна лээ шүү дээ 63 хувь нь.

Тэгэхээр ийм хэрэглээний гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт дээр ингээд л уулзалт хийгээд л ямар ч үр дүнгүй хараад суугаад байх юм уу? Яг ямар төлөвлөгөө та бүхэнд байгаа юм бэ? Төрийн зүгээс энэ гурилын үйлдвэрүүдтэйгээ яаж ойлгуулах юм.

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Д.Есөн-Эрдэнэ: Гурилын үйлдвэрүүдтэйгээ уулзалтаа хийсэн. Тэгээд үнэ өсөхгүй байх тал дээр нэлээн яриа хэлэлцээрүүд хийсэн л дээ. Тэгээд гаалиар бас 400 гаруй төрлийн хүнсний болон Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн гаалийн татварыг бас хөнгөлж байгаа. Мөн түрүүний хэлсэн зээлүүдийг олгож байгаа юм. Тэгээд энэ хүрээндээ танайх үнэ нэмэхгүй байх талаар анхаарч ажиллаач гэсэн шаардлагыг л хүргүүлж байгаа юм.

Ж.Батжаргал: Аубакир гишүүн асуултаа асууя.

Т.Аубакир: Баярлалаа. Шударга өрсөлдөөний хийсэн судалгаатай холбоотой асуулт асууя даа. Яах вэ зүгээр бид нар бас энэ жил 400 орчим мянган тонн улаан буудай л хурааж авлаа л даа. Бид нар Монгол Улсын хэмжээнд дөчхөн мянган тонн улаан буудай хурааж байсан бас цаг үе бий. 2008 оноос хойш Атрын 3 дугаар аян яваад механикжуулалтын асуудал ургамал тэр хор бордоо грибцидийн

асуудлыг шийдээд өнөөдөр бид нар өдий зэрэгтэй бас тариа хураагаад явж байгаа юм. Энэ маань бас л Монгол Улсын Засгийн газрын, Улсын Их Хурлын хийсэн ажлуудын л нэг л дээ. Тэгээд энэ шударга өрсөлдөөний хийсэн судалгаа бол жосохон учир дутагдалтай байна яах вэ. Тийм зээл олгосон юм байна. Тэр зээлээ зориулалтын бусаар ашиглачихсан юм байна гээд л одоо энэ нийгэмд үргэлжлээд байгаа нэг л хэрэг төвөг хайсан нэг тийм салхитай л нэг тийм л судалгаа болчихож байгаа юм.

Гурилын үйлдвэрийнхний гол түүхий эд улаан буудай сая Батжаргал гишүүн хэлж байна шүү дээ. Гурилын үйлдвэрийнхний гол түүхий эд болсон улаан буудайн үнэ яагаад өсчихсөн юм бэ гэдэг дээр үнэхээр шударга өрсөлдөөнийхөн шударга судлах гээд байгаа юм бол тэрийг нь судалж үзмээр байгаа юм. Та нар хэлж байх шиг байна. Улаан буудайн үнэ 25 хувийн өсөлттэй гэж үгүй. Энэ 25-аас дээшээ бараг 40-өөд хувь өсчихсөн байгаа. Өнгөрсөн жил 640 орчим мянган төгрөгөөр өгч байсан улаан буудай энэ жил нэг чанар стандарт янз бүрийн юмнаасаа шалтгаалаад 820-оос 960 орчим мянган төгрөг л байгаа. Сая гаран төгрөгийн шаардлага хангасан улаан буудай Монголд бараг байхгүй дээ.

Тийм учраас энэ улаан буудайн үнэ юунаас болоод өсчхөв өө. Сая Хөдөө аж ахуйн яамныхан хэлж байна шүү дээ. Бид нар манай Монгол Улс энэ улаан буудай үйлдвэрлэхтэй холбоотой нэг ч зүйлээ бид нар үйлдвэрлэдэггүй. Хор бордоо, геребцид, боолт гайхиа хүртэл техник, түли шатахуун бүх зүйлийг импортоор үнэтэй аваад тариалан эрхлэгчдийгээ яаж хямдхан улаан буудай үйлдвэрлэ гээд шахах гээд байгаа юм бэ? Энэ чинь нэг бол алдагдалтай ажиллах ёстой юм уу?

Тийм учраас тэр үнэтэй улаан буудайг авчихсан гурилын үйлдвэрийнхэн чинь 100 төгрөгийн ашиг өгөөд л гурилаа үйлдвэрлэж байгаа шүү дээ. За яах вэ хөнгөлөлттэй зээл авсан юм байна. Тэрний цаана ажиллаж байгаа ажиллагсдын ажлын байр бий болгож байгаа ажиллагсдын цалин, тээвэр, транспортын үнэ, тог цахилгааны үнэ гээд бүх зүйл нэмэгдчихсэн энэ үед гурилын үйлдвэрийнхнийгээ та нар хямдхан гурил үйлдвэрлэ гэж шахах боломж байхгүй.

Энэ та нар судлах гэж байгаа бол ерөөсөө импортоор орж ирсэн улаан буудайн гурил сая 200 мянган төгрөг байлаа гэж бодоход та нар сая 200 мянгаас дээшээ гаргавал төрийн тохируулга ажиллаад импортоор бид нар оруулна шүү гэдэг тохируулгын асуудлаа л ярих ёстой.

Импортын улаан буудайн үнэ ямар байгаа юм бэ? Сая та бүхэн хэлж байх шиг байна. Хөдөө аж ахуйн яамнаас үнээ зарладаг гэж. Энэ жилийн үнэ зарлахад Болорчулуун сайд харин ч Оросын импортын улаан буудайн үнэ дээр түшиглэж байж зарласан үнэ байхгүй юу. Импортоор орж ирвэл тэдэн төгрөгөөр орж ирэх юм байна. Та нар газар тариалан эрхлэгчдэд улаан буудайгаа ийм үнээр зарна шүү л гэсэн үнэ тогтоож өгдөг.

Тийм учраас энэ шударга өрсөлдөөнийхөн маань дахиад энэ судалгаагаа аягүй нарийвчилмаар байна. Тэр хямдхан зээл авчихсан юм байна. Тэр нөхөр нь тэр зээлээ төлөөгүй юм байна гээд. Ингээд гэмт хэргийн шинж чанартай юм яриад байж байхаар үгүй энэ улаан буудай үнэ яг яагаад өсөөд байгаа юм бэ гэдгийг та нар нэг судлаад үзээрэй. Хөдөө аж ахуйн яам чадах чинээгээрээ л ажиллаад явж байгаа.

Дээрээс нь зөвхөн улаан буудай эрхлэгч биш. Сая энэ жил хүнсний ногоо үйлдвэрлэгчдийнхээ техникийн үнийг 50 хувь хүртэл хямдруулж өглөө. Түли шатахуунаа үргэлж л хямдралтай өгөөд л ингээд нөгөө газар тариаланчдаа бас дэмжээд л явдаг юм л даа.

Тийм учраас миний хэлэх гээд байгаа зүйл бол энэ судалгаагаа та нар маань дахиад нэг хийгээд үзвэл яасан юм бэ? Нэг авсан зээлийн л асуудал яасан болохоос биш гол түүхий эд улаан буудай үнэ яагаад өсчихсөн юм гэдгийг судлаагүй л байна л даа. Тэгээд дээрээс нь сая Бейсен гишүүн бас хэлж байна.

Бид нар дараагийн Байнгын хорооны хуралдаанаар энэ үнийн өсөлттэй холбоотой гурил, тэжээлийн гаалийн импортын татварыг чөлөөлөх асуудлыг дараагийн Байнгын хорооны хурлаар ярихаар тохирч байна. Бас л энэ үед бид нар энэ хүнд хэцүү цас зудтай байгаа үед бас нэг малчдадаа нэг хямдхан тэжээл нийлүүлчих бололцоог Хөдөө аж ахуйн яамныхан бас судлаарай. Энэ дээр танайх бас оролцох байх. Энэ онцгой комиссын хурал дээр санал байна.

Ж.Батжаргал: Саяын хэлэгдсэн саналуудыг анхаараарай.

Надад 2, 3 зүйл байна.

Нэгдүгээрт тэр хөнгөлөлттэй зээл буюу дэмжлэгийн эх үүсвэрийн гэрээн дээр тодорхой үүрэг хүлээцгээгээд байгаа юм байна. Тэгээд тэр гэрээ дүгнэхгүй байна гэдэг юм яригдаад байх юм. Тэр гэрээг дүгнэж хэн нь ямар үүрэг хариуцлагатай байх юм гэрээ зөрчигдвөл яах юм гэдэг энэ асуудлаа ер нь дүгнэж барьж холбогдох шийдэл юмаа гаргасан юм байна уу? Нэг ийм асуулт байна.

Хоёрдугаарт **Шударга** өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар дээр үндэслэлгүй үнэ нэмжээ. Та хэд торгосон бололтой юм аа? Үгүй тэгээд үндэслэлгүй нэмэгдчихсэн юман дээр торгуулиас өөр ямар зохицуулалт байна аа? Тэр хий өсөлт авчхаад байгаа юмыг яаж зохих түвшинд нь аваачих ёстой юм бэ? Ямар эрх зүйн тийм зохицуулалт та хэдэд арга механизм байна? Энэ дээрээ нэг тов тодорхой хариулт өгмөөр байна.

Дараагийн нэг зүйл ер нь энэ тэжээлийн асуудал нэлээн яригдаад байгаа юм аа. Гурилын үйлдвэрүүд дээр чинь тэжээлийн нөөц ер нь ямархуу юм байна вэ? Өөрсдийнх нь склад саванд байж байгаа тэжээлийн будааны үлдэгдэл хэр байгаад байгаа юм бэ? Цаашид энэ хангалт нийлүүлэлт чинь ер нь ямар түвшинд явах юм бэ? Энэ тал дээр бас нэг тодорхой хариулт өгөөдхөөч? Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Хүнс, хөдөө аж ахуйн яам эхлээд тэр гэрээ юуны талаар тэжээлийн будаатай холбоотой асуудлаар хариулт өгөөдөх.

Д.Есөн-Эрдэнэ: **Нөөц** бүрдүүлэлтээр 3 зуугаад тонн улаан буудайн нөөц байгаа. Хивгэн дээр болохоор хивэгний асуудал дээр болохлоор яг нөгөө нөөцийн хувьд бол өчигдөр бид нар нөгөө Онцгой байдлын ерөнхий газар дээр хуралдаад уулзахад энэ гурилын үйлдвэрүүд дээр саяын цас орсонтой холбогдуулаад бөөнд нь нэлээн тийм аймгууд ингээж юугаар авчихсан юм байна лээ. Тэгээд яг хэвийн үйлдвэрлэл явагдаж байна. Буцаад хэвийн юундаа шатдаа орчихно гэдгийг гурилын үйлдвэрүүд мэдэгдэж байна лээ. Хивгэн дээр бол. Тэр гэрээний асуудал дээр бол яг гэрээг бол яг энэ 36 дугаар тогтоолын хүрээнд бол хөнгөлөлттэй зээл олгож байгаа. Энэ

дээр бол яг зээл авсан яг чиглэлээрээ яг тэр ашиглалтыг нь хариуцаж энэ зориулалтын дагуу яг ашиглах гэдэг тал дээр л гэрээ ер нь хийгдэж байгаа юм.

Тэгэхээс тэр үнийн өсөлтийн юун дээр бас дахиад нэмж хэлэхэд түрүүн бас Аубакир гишүүн хэлж байна. Энэ гурилын үйлдвэрүүд яг энэ ашиглалтынхаа дагуу яваад 20 хувь ч юм уу 30 хувийн ашгаа ингээд хийгээд худалдаалалт дээр гаргаж байгаа. Эндээсээ бас гараад нөгөө ченжийн асуудал гэж нэг асуудал байгаад байгаа юм. Ченжүүд бас энийг нь бас дамжуулж хөдөө орон нутаг руу явуулаад үнээ нэмэгдүүлэх гэсэн бас нэг асуудлууд байгаа. Энийг бас энэ шударга өрсөлдөөний газрыг бас судлаад өгвөл бас зүгээр байна гэж.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар танай дүгнэлт дотор гэрээнийхээ биелэлтийг тооцохгүй байгаагаас үүдээд энэ юманд чинь нөлөө үзүүлээд байна шүү гэдэг нэг дүгнэлт орж ирсэн.

Хоёрдугаарт бас үндэслэлгүй байх үндэслэл байна гэдэг юм орж ирсэн. Тэгээд танай авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ 2 аж ахуйн нэгж дээр зөрчлийн хэрэг үүсгээд торгуулийн асуудал яригдаад шүүхийн шатанд явж байгаа гэдэг юм яриад байгаа юм. Торгож болдог юм байж. Өөр яаж зохицуулалт хийдэг эрх зүйн зохицуулалт байна вэ? Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

У.Халиунаа: Хууль эрх зүйн орчны хувьд бол шийтгэл оногдуулж торгохоос өөрөөр бол нөгөө давамгай, монопол, зүй ёсны монопол болон давамгай талтай аж ахуй эрхлэгч биш учраас бид нар шууд үнийг нь яг ийм түвшинд буулга, тэдэн хувиар буулга гэдэг ийм шаардлагыг тавих эрх зүйн

зохицуулалт бид нарт байхгүй 1 дүгээрт.

Хоёрдугаарт, түрүүн үнийн өсөлтөд нөлөөлж байгаа хүчин зүйлийг бас түрүүний өмнөх гишүүний юун дээр бас тайлбар хэлэхэд хүчин зүйлийг бол бид нар судалгааныхаа явцад гаргасан. Бид нар яагаад энэ үнэ үндэслэлгүй байна вэ гэж үзсэн бэ гэвэл тухайн аж ахуй эрхлэгчид маань өөрсдөө нөөц бүрдэлтээ өөрсдөө 600-аас 680 мянган төгрөгийн хооронд хийчхээд тэр хямд авсан нөөцөөрөө үнээ хамгийн дээд тал нь 10 удаагийн гүйцэтгэх захирлын тушаалаараа нэмэгдүүлсэн байдаг. Тэр нь өөрөө 52.6 хувиар өсчихсөн. Тэр 10 удаагийн нэмэгдэл явсаар байгаад.

Гэтэл тэр улаан буудайнаас бусад хүчин зүйл цалин Нийгмийн даатгалын шимтгэл өөр юу байдаг юм. Цахилгаан, ус, дулаан гээд хэрэглээнийхээ бүх зардлууд нь 0.3-2.4-хөн хувийг л эзэлж байдаг тэр өртгийн.

Гэтэл бид нар энэ судалгаагаа нарийвчилж нэг бүрчлэн судлаад гаргаад нийт гурилын өртөг нь өөрөө 890 орчим төгрөг байна гэдэг ийм эдийн засгийн судалгааг гаргаад аж ахуй эрхлэгчдийн өөрсдийнх нь гаргаж байгаа судалгаа одоо зах зээл дээр нийлүүлж байгаа үнийг нь ингээд харахаар зэрэг үндэслэлгүй ийм үнэ тавьсан байна. Тэр нь өөрөө Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн байна гэж үзсэн учраас бид нар торгуулиа оногдуулсан.

Тэр нь 3 аж ахуйн нэгж дээр бид нар торгууль оногдуулсан. Алтан тариа компанийн хувьд бол Гурил үйлдвэрлэгчдийн холбооны нэгдсэн холбооны гишүүн аж ахуйн нэгж биш учраас Өрсөлдөөний хуулийн 12.1.10-аар хууль бус худалдааны арга хэрэглэсэн гэдгээр бол шийтгэл оногдуулаад явсан ийм тохиолдол байгаа.

Ж.Батжаргал: Асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж санал хэлэх гишүүд байна уу? Идэрбат гишүүнээр тасаллаа. Идэрбат гишүүн саналаа хэлье.

Ц.Идэрбат: Тэгээд энэ гурилын үнийн асуудал дээр үйлдвэрүүд нь үйл ажиллагаагаа зогсчихгүй Монголчууд гурилаар тасарчихгүй гэхдээ үнэ нь өсчихгүй тэгээд бид нэг ийм л хувилбарыг авахаас өөр аргагүй шүү дээ.

Тэгэхээр энэ уулзалт энэ Байнгын хорооны энэ нэг мэдээлэл сонсож байгаа энэ үйл явц ингээд зогсохгүйгээр Хөдөө аж ахуйн яам ч гэсэн ингээд нэг Байнгын хорооны хурал болоод өнгөрлөө гэхгүйгээр энэ гурилын үнийн шалтгааныхаа асуудлыг энэ гурил үйлдвэрлэгч нартайгаа бас нэлээн сайн ойлголцож ярьж энэ дотооддоо л юмаа үйлдвэрлэдэг болъё гэсэн тэр зарчмаа бас алдаж болохгүй шүү дээ бид нар.

Тэгэхээр энэ юмаа барьж гэхдээ бас ингээд хуйвалдаад үнээ нэмээд байж болохгүй. Ард нь энэ чинь улс даяараа хохирдог юм байна гэдгийг би уул нь аминдаа л та бүхэнд бас тайлбарлалаа. Та бүхэн мөнгөний бодлогын тэр бодлогын хүү 13 чинь та нараас болж байна. Хөдөө аж ахуй тэр дундаа гурилын үнээс болж байгаа гэдгийг ойлгосон болов уу гэж ингэж бодож байна. Тэгээд энэ чинь жирийн бизнес эрхлэгч нарт хүртэл дарамт болж байгаа шүү дээ энэ чинь.

Тэгэхээр энэ дээр манай Байнгын хороо ч гэсэн ер нь эндээс бас нэг тодорхой чиглэл өгөөд энэ байгууллагууд холбогдох байгууллагууд нь юу хийж байгаа талаар бас тодорхой хугацааны дараа эргэж мэдээллийг нь

сонсох ийм юм руугаа орвол яасан юм бэ? Зүгээр ингээд нэг сонсоод өнгөрдөг баймааргүй байна гэж 1 дүгээрт санал байна.

Хоёрдугаарт энэ олон энэ тариалан эрхлэгч нар яриад байна аа. Энэ улаан буудайн борлуулалтын асуудал. Чанартай чанаргүй янз янз л байна. Энэ ААН-үүдийн борлуулалтын асуудал дээр та бүхэн маань онцгой анхаарч гадагш нь гаргах экспортлох энэ боломжуудыг нээж өгөхгүй бол ирэх хавар тариалалт хийх компани ер нь хэр олон байгаа болдоо. Надтай энэ төвийн бүсэд тариалан эрхэлж байгаа хүмүүс ч энэ талаар бас мэдээллүүд ирүүлж байна. Би орон нутагт Хэнтийн хойд талын сумдаар явахад ч гэсэн борлуулж чадахгүй байна яана л гэсэн ийм хүмүүс. Одоо нөгөө 3 хувийн хүүтэй зээлүүдээ төлөх хугацаа нь болчхож байгаа юм байна лээ шүү дээ. Тэгээд ингээд маш хүнд байна.

Хэрвээ энийг ингээд давж гарч чадахгүй бол ирэх хавар юун тариалалттай манатай гэж байгаа шүү дээ. Тэгэхээр нөгөө ирэх хаврын тариалалтын асуудал чинь Үндэс суурь нь одоо байгаа ААН-үүдээ дэмжих юм байна лээ шүү дээ. Тэгэхээр наад экспортын боломж бололцоонуудыг нь нэг дорвитойхон шиг нээх тал дээр хурдхан шиг ажиллаж өгөөч ээ. Энэ яам, Тамгын газрынхны нөгөө судална гэдэг үг бол тэгээд их л хэцүү л сонсогддог юм даа. Яг л ийм л зүйл ярьж байна лээ. Судална л гэж яриад байгаа. Бүү мэдээ юу болж байгаа юм. Тэгэхээр энэ тариалан эрхлэгчдээ бид бас бодохгүй бол болохгүй шүү. Ирэх хавар амжиж зоохгүй болчих вий дээ гэж ингэж бас бодож байна. Өр ширнээс гарч чадахгүй болчих вий дээ.

Гуравдугаарт би энэ Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар энэ мэдээлэл эд нар юмнуудыг нь харахаар

дандаа энэ даргын үүрэг гүйцэтгэгчүүд байгаад байгаа юм уу даа гэж ингээж харж байгаа юм. Тэгэхээр та бүхний хийх ажил энэ инфляц ийм өндөр түвшинд байгаа ийм цаг үед бол би нэлээн танай байгууллага үндсэн үйл ажиллагаа чинь нэлээн сайн явахгүй бол болохгүй ээ.

Тийм учраас энэ Байнгын хорооны зүгээс энэ шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын энэ төрийн захиргааны алба хаагчид байдаг юм уу тэр холбогдох хуулийн дагуу бол яаралтай шийдэх энэ асуудлыг бас яривал яасан юм бэ гэж ингээж бас хэлэх гээд байгаа юм. Одоо ингээд инфляцад гурил нөлөөлж байтал магадгүй шатахуун нөлөөлж эхэлнэ шүү.

Чуулганы хуралдаан дээр уул уурхайн сайд Ганбаатар сайд юу гэж хариулсан бэ гэхээр Оросоос орж ирж байгаа бензин шатахууны үнэ бол 930 байсан одоо 850 руу орж ирж байгаа гэсэн ийм зүйлийг ярьж байна лээ. Шатахуун түгээх станцууд дээр орон нутагт бол үнэ нь нэмэгдээд оччихоод байгаа. БНХАУ-аас бол бас арай үнэтэй. 1090 доллароор авч байгаа гэж байгаа юм. Тэгээд энэ болгон чинь бас л инфляцад нөлөөлөөд, Инфляц нэг оронтой тоо руугаа орно гэж байхгүй дахиад юмны үнэ өсөх вий. Тэгвэл энэ баахан цалин тэтгэврийн нэмэгдэл юмнууд чинь бүгд үнс болно шүү.

Тийм учраас энэ Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын энэ үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хуульд заасан үүргээ биелүүлэх бололцоонуудыг нь бас хангаж өгөх нь зүйтэй юм уу.

Ж.Батжаргал: Уг асуудлыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээд тов тодорхой мэдээлэл юмнууд тогтоож авсан. Сая Байнгын хорооны хуралдаанд гишүүд дараагийн

хуралдаанаар энэ МАА-н өвөлжилтийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг Байнгын хорооны дараагийн хуралдаанаар сонсьё оо гэж ингээж тогтоод хэлэлцэх асуудал цаглавраа баталчихсан.

Тийм учраас Байнгын хорооны дараагийн хуралдаанд энэ өвс тэжээлийн хангалт, нийлүүлэлт, энэ гурил тэжээлийн үнийн зохистой байдал энэ талын бүх мэдээлэл орж ирнэ шүү. Тийм учраас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам энүүн дээрээ онцгой анхаарал хандуулаарай гэдгийг зориуд хэлмээр байна.

Бид ажлын албанаасаа холбогдох төрийн байгууллагуудад мэдээлэл бэлтгэж ирүүлэх чиглэл хугацаануудыг нь тусгайлан өгнө гэдгийг зориуд хэлье ээ. Дээр нь энэ аливаа асуудлыг бид хэлэлцээд, тов тодорхой мэдээлэл, зохицуулалтаа хангаж л гарч байх ёстой.

Тийм учраас энэ гурилын үнийн өөрчлөлт түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийн талаар холбогдох байгууллага тов тодорхой судалгаа хяналт шалгалт хийлээ. Гарч ирж байгаа дүгнэлтдээ өөрсдөө эзэн байх ёстой. Тийм учраас энийгээ баталгаатай хангаж тэр холбогдох хуулиар өөрсдөдөө олгогдсон эрх мэдлийнхээ хүрээнд холбогдох арга хэмжээнүүдийг нь авч ажиллаарай гэж би Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрынханд зориуд хэлмээр байна. Энэ холбогдох байгууллагуудаас очсон хяналт шалгалтын дүгнэлт мэдээллийг авсан байгууллагууд нь цаад уг эрх нь хөндөгдөж байгууллагуудтайгаа ярилцаж хууль зүйд нийцүүлэх тодорхой цаг алдалгүй шуурхай арга хэмжээнүүд авах асуудлыг хийх ёстой.

Би үндсэндээ 7 сард Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд энэ мэдээлэл бүх юм очсон юм байна. Тэрний мөрөөр зохиож байгаа ажил нь 3, 4 удаагийн уулзалт байгаа юм байна. Тодорхой үр дүнд хүрсэн гэдэг юм уу ийм зүйл болжээ гэж дуугарахад бас нэлээн тийм бүдэг ийм л асуудал болчихоод байна.

Тэгэхээр зэрэг энэ гэрээний хэрэгжилтийг хэрхэн яаж хангах ёстой юм? Энэ төрөөс тодорхой хэмжээний бодлогын дэмжлэг авчхаад тэгээд нөгөө талдаа үүргээ хангах талаар ер нь яаж ажиллах ёстой юм бэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ хангалт нийлүүлэлт үнэ ханишийн тогтвортой байдлыг бид Улсын Их Хурлаас бүүр тусгайлсан хууль баталсан шүү. Тэр

хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар манай холбогдох төрийн байгууллагууд анхаарлаа хандуулж ажиллах ёстой гэдгийг ийм зориуд үүрэг чиглэлийг өгч байна аа.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан өндөрлөлөө.

13.25 цагт

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА